



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах" аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, нийцлийн аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайлан, ажлын баримтыг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын архивд шилжүүлж, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор /С.Энхбаатар/-т даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч бөгөөд Тэргүүлэх аудитор /О.Тэнгис/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар:	Товчилсон үгийн жагсаалт.....	3
	Хүснэгтээр үзүүлсэн мэдээллийн жагсаалт	3
<i>НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор</i>	Аудит хийх үндэслэл.....	4
<i>С.Энхбаатар</i>	Аудитын зорилт	4
<i>НАГ-ын менежер</i>	Аудитын хамарсан хүрээ.....	4
<i>Х.Болдбаатар</i>	Аудитын арга зүй.....	4
<i>Ахлах аудитор</i>	Үндсэн мэдээлэл.....	5-6
<i>Д.Отгонбаяр</i>	БҮЛЭГ 1. 2017-2018 ОНД ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ЗАРИМ ГЭРЭЭЛЭГЧ ӨРТӨГ НӨХӨХ ЗАРДЛЫГ ҮНЭН ЗӨВ БҮРТГЭЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.	7-12
<i>Ахлах шинжээч</i>	1.1. Гэрээлэгчид санхүүгийн анхан шатны баримтгүй болон өртөг нөхөгдөхгүй зарим зардлыг ӨНЗ-ын тайланд тусгаж, бүртгэсэн байна.....	7-10
<i>Б.Өлзий</i>	1.2. Гэрээлэгчид БХГ-ээр хүлээсэн зарим чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна	11-12
<i>Аудитор</i>	БҮЛЭГ 2. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.	13
<i>С.Сугармаа</i>	2.1. АМГТГ нь гэрээлэгчийн ӨНЗ-ын тайланг хяналт тавилгүйгээр хүлээж авсан байна.....	13
<i>В.Орхон</i>	Дүгнэлт.....	14
<i>П.Магнайбаатар</i>	Зөвлөмж.....	15
2020 оны 04 дүгээр сар	Хавсралт 1.....	16
Тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	Холбогдох байгууллагын санал.....	17-41
<i>Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261749, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.</i>	Саналд өгөх тайлбар	42-43
Хаяг: Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын ІҮ байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс		



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БХГ	МУЗГ-ын 2015 оны 104 тогтоолоор баталсан загварын дагуу байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” Дээрх загвар батлагдахаас өмнө байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал

ХҮСНЭГТЭЭР ҮЗҮҮЛСЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	АМГТГ-аар хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлуулсан болон хайгуулын үйл ажиллагаа явуулсан талбайн мэдээлэл
Хүснэгт 2	Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагдсан хугацааны мэдээлэл
Хүснэгт 3	Газрын тосны 9 хайгуулын талбайд 2017-2018 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын мэдээлэл
Хүснэгт 4	Гэрээлэгчдийн АМГТГ-аар батлуулсан хайгуулын ажлын төсөв, гүйцэтгэл, ӨНЗ-д тайлагнасан дүн болон тус аудитаар ӨНЗ-аас хасаж баталгаажуулсан зардлын мэдээлэл
Хүснэгт 5	Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн Богд-IV болон Онги-V талбайн ӨНЗ-аас хасаж тооцсон зардлын мэдээлэл
Хүснэгт 6	“Петроматад инвест лимитэд” компанийн Матад-XX талбайн 2017, 2018 оны ӨНЗ-аас хасаж тооцсон зардлын мэдээлэл
Хүснэгт 7	"Монголын алт" ХХК, "Макс ойл" ХХК, "Смарт ойл Монголиа" ХХК, "Вульф петролеум" ХХК, "Магнай трейд" ХХК -ийн хайгуулын гэрээт 5 талбайн өртөг нөхөх зардлаас хасагдсан дүнгийн мэдээлэл
Хүснэгт 8	“Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн гэрээт Богд-IV болон Онги-V, “Петроматад инвест лимитэд” компанийн гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн зардлын мэдээлэл
Хүснэгт 9	“Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компани нь Богд-IV болон Онги-V хайгуулын талбайн АМГТГ-т хүргүүлж, хянуулаагүй гаргасан зардлын мэдээлэл
Хүснэгт 10	Хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлээгүй талбайн мэдээлэл
Хүснэгт 11	2017, 2018 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан боловч хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй талбайн мэдээлэл
Хүснэгт 12	Хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээлэгчдийн АМГТГ-аар батлуулсан жилийн ажлын төсөв болон гүйцэтгэлийг харьцуулалт



Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.21, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2-т тус тус заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 04 дүгээр тогтоол, МҮЕА-ын 2019 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2019 онд хийх аудитын төлөвлөгөө”-ний хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн 2017, 2018 оны хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасныг хянан баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Тухайн зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- 2017, 2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлыг Бүтээгдэхүүн хуваах гэрээ, холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэх;
- Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох байгууллагууд Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон хууль, тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсын Засгийн газартай байгуулсан БХГ-ний дагуу 2017, 2018 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан “Вульф петролеум” ХХК, “Петроматад Инвест Лимитед”, “Зон Хэн Юу Тиан” ХХК, “Магнай Трейд” ХХК, “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед”, “Макс Ойл” ХХК, “Смарт ойл Монголиа” ХХК, “Монголын Алт” ХХК зэрэг 8 гэрээлэгчийн хайгуулын 9 талбайн 2017, 2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсөв, ӨНЗ-ын тайлан, холбогдох бусад баримт материал, АМГТГ дахь холбогдох тайлан, баримт материалыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Газрын тосны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, аудитад хамрагдсан гэрээлэгч компаниудын Бүтээгдэхүүн хуваах гэрээний холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон Төрийн аудитын тухай хууль, АДБОУС 100, 400, 4000 болон Төрийн хяналт шалгалтын стандарт, МҮЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”, 2018 оны А/139 дүгээр тушаалаар баталсан “Газрын тосны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудитын заавар”-ыг тус тус баримтлан ажиллав.

Гэрээлэгчдээс гэрээт газрын тосны хайгуулын талбайн 2017, 2018 оны ӨНЗ-д тайлагнасан хайгуулын үйл ажиллагааны зардлын бүртгэлийг Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний холбогдох заалтууд, АМГТГ-т хүргүүлсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, холбогдох бусад баримт материал болон санхүүгийн тайлан, ӨНЗ-ын тайлан, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журнал, ерөнхий дэвтэр, анхан шатны баримтуудтай тулган баталгаажууллаа.

Мөн холбогдох байгууллага, албан тушаалтнаас тайлбар авах, цооног өрөмдсөн хайгуулын талбайд ажиллаж, гүйцэтгэлийг газар дээр нь тулган баталгаажуулах, АМГТГ-аас хянан хүлээн авсан баримт материалыг нягтлан шалгах зэргээр нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.



Үндсэн мэдээлэл

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 31 талбай ялгаснаас АМГТГ 22 талбайд 19 гэрээлэгч хуулийн этгээдтэй БХГ-г байгуулж¹, Монгол Улсын Засгийн газраар батлуулсан бөгөөд МУЗГ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан загварын дагуу БХГ-г шинэчлэн байгуулсан байна.

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3² болон БХГ-нд заасны дагуу хайгуулын талбайд тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг АМГТГ-аар жил бүр батлуулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн боловч 2017-2018 онд зарим гэрээлэгч дээрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1.

Хугацаа	АМГТГ-тай БХГ байгуулсан хайгуулын талбай /тоогоор/				
	Нийт	Төлөвлөгөө, төсөв Батлуулсан	Төлөвлөгөө, төсөв батлуулаагүй	Үйл ажиллагаа явуулсан	Үйл ажиллагаа явуулаагүй
2017	22	12	10	9	13
2018	22	14	8	9	13

Эх сурвалж: АМГТГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/441 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

Иймд тус аудитад АМГТГ-аар батлуулсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулсан 8 гэрээлэгчийн 9 хайгуулын талбайн хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг хамруулж, баталгаажуулсан бөгөөд БХГ-г байгуулсан хугацааг Хүснэгт 2-д үзүүлэв.

Хүснэгт 2.

№	Гэрээлэгч компани	Хайгуулын талбай	БХГ-г байгуулсан хугацаа	
			2015.03.16-ны өдрөөс өмнө	МУЗГ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолын дагуу
1	“Сентрал Азиан	Богд-IV	2009.07.08	2018.06.05
2	Петролеум Корпорэйшн Лимитэд”	Онги-V	2009.07.08	2018.06.05
3	“Петроматад Инвест Лимитэд”	Матад-XX	2006.05.26	2018.06.08
4	“Зон Хэн Юу Тиан” ХХК	Галба-XI	2009.04.27	2019.01.17
5	“Магнай трейд” ХХК	Баян-түмэн-XVII	2009.12.23	2018.06.08
6	“Монголын алт” ХХК	Төхөм-X урд	2012.07.06	2017.06.16
7	“Вульф петролеум” ХХК	Сүхбаатар-XXVII	2013.01.02	2017.06.16
8	“Макс ойл” ХХК	Арбулаг-XXIX	-	2016.07.06
9	“Смарт Ойл Монголиа” ХХК	Эргэл-XII	-	2016.06.09

Эх сурвалж: АМГТГ-ын 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1/4932 тоот албан бичгээр ирүүлсэн БХГ-ний хувь

Газрын тосны 9 хайгуулын талбайд 2017-2018 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын мэдээллийг Хүснэгтээр үзүүлбэл:

¹ 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

² 11.2.3.жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;



Хүснэгт 3.

№	Гэрээлэгч компани	Хайгуулын талбай	Гүйцэтгэсэн хайгуулын ажлын мэдээлэл	
			2017	2018
1	“Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд”	Богд-IV	Чичирхийллийн багцлалтын өмнөх гүний миграцийн боловсруулалт, 2 хэмжээст чичирхийллийн ажлыг 10 шугам дээр гүйцэтгэсэн.	2 хэмжээст чичирхийллийн хээрийн ажил, Тахь-1 цооног өрөмдсөн.
2		Онги-V	3 хэмжээст чичирхийллийн хээрийн хэмжилт хийсэн.	Хайгуулын тулгуур Ирвэс-1 цооног өрөмдсөн.
3	“Петроматад Инвест Лимитэд”	Матад-XX	2 хэмжээст чичирхийллийн багцлалтын өмнөх гүний миграцийн боловсруулалт хийсэн.	Гүехэн цооногоос 32 ширхэг дээж авсан.
4	“Зон Хэн Юу Тиан” ХХК	Галба-XI	-	“Доншен газрын тос Монгол” ХХК-ийн Зүүнбаян дахь газрын тос хадгалах цэгт 708,6 тонн газрын тос буулгасан.
5	“Магнай трейд” ХХК	Баянтүмэн - XVII	-	Цооног өрөмдөх байсан боловч орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс зогссон.
6	“Монголын алт” ХХК	Төхөм-X урд	-	2 хэмжээст чичирхийллийн судалгаа болон үр дүнгийн тайлан боловсруулалт хийсэн.
7	“Вульф петролеум” ХХК	Сүхбаатар - XXVII	-	-
8	“Макс ойл” ХХК	Арбулаг-XXIX	AR2017-01 цооног өрөмдсөн.	AR2018-02 цооног өрөмдсөн.
9	“Смарт Ойл Монголиа” ХХК	Эргэл-XII	Геологийн болон геофизикийн судалгаа хийсэн.	-

Эх сурвалж: АМГТГ-ын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 1/4972 тоот албан бичиг.



БҮЛЭГ 1. 2017-2018 ОНД ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ЗАРИМ ГЭРЭЭЛЭГЧ ӨРТӨГ НӨХӨХ ЗАРДЛЫГ ҮНЭН ЗӨВ БҮРТГЭЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

1.1. Гэрээлэгчид санхүүгийн анхан шатны баримтгүй болон өртөг нөхөгдөхгүй зарим зардлыг ӨНЗ-ын тайланд тусгаж, бүртгэсэн байна.

Аудитад хамрагдсан 9 талбайн гэрээлэгчид хайгуулын үйл ажиллагаанд нийт 68,688,697.7 ам.долларыг зарцуулахаар төсөв батлуулсан ч нийт 31,869,716.9 ам.долларыг зарцуулж, үүнээс ӨНЗ-д 27,484,833.2 ам.долларыг бүртгэж, тайлагнасан байна.

Гэрээлэгчдийн АМГТГ-аар батлуулсан хайгуулын ажлын төсөв, гүйцэтгэл, ӨНЗ-д тайлагнасан дүн болон тус аудитаар ӨНЗ-аас хасаж баталгаажуулсан зардлын дүнг талбай тус бүрээр Хүснэгт 4-т үзүүлбэл:

Хүснэгт 4.

№	Гэрээлэгч компани	Талбайн нэр	2017-2018 он /ам.доллар/				
			Төсөв	Гүйцэтгэл	ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Баталгаажсан ӨНЗ
1	"Сентрал азин петролеум"	Богд IV	10,039,054.9	9,870,501.1	9,105,223.5	716,214.0	8,389,009.5
2	корпорэйшн лимитэд" ХХК	Онги V	15,327,264.2	13,510,635.8	12,814,450.8	346,556.0	12,467,894.8
3	"Петро матад" ХХК	Матад ХХ	3,750,227.2	1,186,458.3	621,911.2	31,760.9	590,150.3
4	"Монголын алт" ХХК	Төхөм Урд Х	5,417,570.4	1,114,420.7	357,141.8	4,047.1	353,094.6
5	"Макс ойл" ХХК	Арбулаг ХХХ	5,834,164.1	4,422,024.2	3,614,669.7	172,128.6	3,442,541.1
6	"Смарт ойл Монголиа" ХХК	Эргэл XII	2,034,205.0	462,893.0	78,750.0	3,750.0	75,000.0
7	"Вульф петролеум" ХХК	Сүхбаатар XXVII	18,994,247.0	460,060.3	147,369.1	6,665.2	140,703.9
8	"Магнай трейд" ХХК	Баянтүмэн XVII	4,636,579.6	644,466.6	588,137.0	560,054.1	28,082.9
9	"Зон Хэн Юу Тиан" ХХК	Галба XI	2,655,385.5	198,256.9	157,180.1	-	157,180.1
Нийт			68,688,697.7	31,869,716.9	27,484,833.2	1,841,175.9	25,643,657.3

Эх сурвалж: АМГТГ-ын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 1/4972 тоот албан бичиг.

Хүснэгтэд үзүүлснээр "Зон Хэн Юу Тиан" ХХК нь ӨНЗ-ыг Газрын тосны тухай хууль болон БХГ-ний дагуу бүртгэж, тайлагнасан тул тус компанийн ӨНЗ-ыг АМГТГ-т тайлагнасан дүнгээр баталгаажуулж, бусад 7 гэрээлэгчдийн 8 талбайн ӨНЗ-ын тайланд зарим зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй зөрчил илэрсэн тул тус гэрээлэгчдийн тайлагнасан ӨНЗ-аас 1,841,175.9 ам.долларын зардлыг хасаж баталгаажуулав. /Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д он тус бүрээр үзүүлэв/

Аудитаар ӨНЗ-аас хасагдсан зардлыг гэрээлэгч бүрээр харуулбал:

"Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд" компанийн гэрээт Богд-IV болон Онги-V талбайн 2017, 2018 оны ӨНЗ-д тайлагнасан нийт 21,919,674.3 ам.долларын зардлаас 1,062,770.0 ам.долларын зардлыг ӨНЗ-аас хасаж тооцсон. Үүнд:



Хүснэгт 5.

Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн Богд-IV болон Онги-V талбайн 2017, 2018 оны ӨНЗ-аас хасаж тооцсон зардал /ам.доллар/

№	ӨНЗ-аас хассан үндэслэл	Богд-IV		Онги-V		Хууль, БХГ-ний заалт
		2017	2018	2017	2018	
1	Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөвт тусгасан дүнгээс хэтэрсэн	1,112	153,845	36,909	-	2009 онд байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 5.6 ³ , 2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4.2 ⁴
2	Тайлант хугацаанд төлөөгүй буюу анхан шатны баримтгүй	-	151,847	-	4,086	ГТТХ-ийн 32.7 ⁵ , 2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4.1 ⁶
3	БХГ-ний дагуу ӨНЗ-ын ангилалд хамаарахгүй	-	1,529			2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4.12 ⁷
4	БХГ-ний дагуу Захиргааны зардалд хамаарах тул захиргааны зардалд шилжүүлэн бүртгэх	291,721	178,797	291,721	178,797	2009 онд байгуулсан БХГ-ний 13.1 ⁸ , Хавсралт Г-ийн 2.1.л ⁹ , 2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний 15.1.1 ¹⁰ , Хавсралт Г-ийн 2.3.11.1 ¹¹
5	Зардал шилжүүлэн бүртгэснээс ӨНЗ-д тооцогдох захиргааны зардлаас хасагдсан	18,006	(80,643)	(35,566)	(129,391)	ГТТХ-ийн 11.1.6 ¹²
	Нийт	310,839	405,375	293,064	53,492	1,062,770

“Петроматад инвест лимитэд” компанийн Матад-XX талбайн 2017, 2018 оны ӨНЗ-д тайлагнасан нийт 621,911.2 ам.долларын зардлаас 31,760.9 ам.долларын зардлыг ӨНЗ-аас хасаж тооцсон. Үүнд:

³ Өртөгт тос болон хийг тодорхойлох зорилгоор доорх зардлыг нөхөн төлөгдөхгүй зардалд тооцно. Холбогдох ажлын хөтөлбөр, төсөв буюу зарлагын батламжлалын хүрээнд зарцуулагдаагүй зардал.

⁴ Өртөг нөхөгдөхгүй зардалд дараах зардлыг хамааруулна. Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн.

⁵ Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй.

⁶ Өртөг нөхөгдөхгүй зардалд дараах зардлыг хамааруулна. Анхан шатны баримт бүрдүүлээгүй, зөрчилтэй, хангалттай баримтжуулаагүй, бүртгэлгүй зардал

⁷ Гэрээний талын ашиг сонирхол, нэр хүндийг дээшлүүлэх, олон нийттэй харилцах харилцааг сайжруулахтай холбогдон гарсан бөгөөд төрийн захиргааны байгууллагаас бичгээр зөвшөөрөгдөөгүй хандив болон бусад зардал

⁸ Гэрээлэгч нь газрын тосны үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хавсралт Г-д заасан журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ...хөтөлнө.

⁹ Захиргааны зардалд Гэрээлэгчийн Монголд буюу гадаад дахь ерөнхий удирдлага болон тэдгээрт туслах ажиллагсад ба тэдгээрийн үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан бодит зардлуудыг бүртгэнэ.

¹⁰ гэрээлэгч эсхүл оператор компани нь газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу ...хөтөлнө

¹¹ Захиргааны зардалд гэрээлэгч эсхүл оператор компанийн Монгол Улсад болон гадаад дахь ерөнхий удирдлага (үүний дотор хувь нийлүүлэгчийн зардал багтана) болон хянах, үйлчлэх, зөвлөх үүрэг бүхий захиргааны ажилтай холбогдон гарах зардлыг бүртгэнэ)

¹² гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх.



Хүснэгт 6.

№	Зардлын төрөл	Матад-ХХ /ам.доллар/		Хууль, БХГ-ний заалт
		2017	2018	
1	Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөвт тусгасан дүнгээс хэтэрсэн	29,312.0	-	2005 онд байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2 дугаар зүйлийн 5.6 ¹³ , 2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4.2 ¹⁴
		100.0	-	
2	БХГ-ний дагуу ӨНЗ-ын ангилалд хамаарахгүй	-	831.2	2018 оны БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4.12 ¹⁵
3	Зардал шилжүүлэн бүртгэснээс ӨНЗ-д тооцогдох захиргааны зардлаас хасагдсан	1,476.1	41.6	ГТХ-ийн 11.1.6 ¹⁶
	Нийт	30,888.1	872.8	31,760.9

Дараах 5 гэрээлэгч ижил төрлийн зөрчил гарган захиргааны зардлыг санхүүгийн анхан шатны нотлох баримтгүйгээр өртөг нөхөгдөх нийт зардлын 5 хувиар тооцож, ӨНЗ-д бүртгэж, тайлагнасан тул нийт 179,092.2 ам.долларын зардлыг ӨНЗ-аас хасаж тооцов. Хүснэгт 7-д үзүүлбэл:

Хүснэгт 7.

№	Гэрээлэгч компани	Талбайн нэр	Захиргааны зардлаас хасагдах дүн /ам.доллар/		Нийт /ам.доллар/	Хууль, БХГ-ний заалт
			2017	2018		
1	"Монголын алт" ХХК	Төхөм Урд-Х	3,314.3	732.8	4,047.1	Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 ¹⁷ , мөн МУЗГ-ын 2015 онд баталсан загварын дагуу байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.1.1 ¹⁸
2	"Макс ойл" ХХК	Арбулаг-ХХIX	84,532.7	79,243.1	163,775.8	
3	"Смарт ойл Монголиа" ХХК	Эргэл-ХII	3,750.0	-	3,750.0	
4	"Вульф петролеум" ХХК	Сүхбаатар-ХХVII	3,334.7	3,330.5	6,665.2	
5	"Магнай трейд" ХХК	Баянтүмэн-ХVII	-	854.1	854.1	
	Нийт		94,931.7	84,160.5	179,092.2	

"Макс ойл" ХХК нь "Арбулаг-ХХIX" хайгуулын талбайн үндсэн хөрөнгийн элэгдлийн нийт 8,352.8 ам.долларын зардлыг ӨНЗ-д бүртгэсэн нь 2016 онд байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4-т "өртөг нөхөгдөхгүй зардалд дараах зардлыг хамруулна", 2.4.22-т "үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл" гэж заасныг тус тус зөрчсөн тул тухайн дүнгээр ӨНЗ-аас хасаж тооцсон.

¹³ Өртөгт тос болон хийг тодорхойлох зорилгоор доорх зардлыг нөхөн төлөгдөхгүй зардалд тооцно. Холбогдох ажлын хөтөлбөр, төсөв буюу зарлагын батламжлалын хүрээнд зарцуулагдаагүй зардал.

¹⁴ Өртөг нөхөгдөхгүй зардалд дараах зардлыг хамааруулна. Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн.

¹⁵ 2.4. Өртөг нөхөгдөхгүй зардалд дараах зардлыг хамааруулна.

2.4.12. Гэрээний талын ашиг сонирхол, нэр хүндийг дээшлүүлэх, олон нийттэй харилцах харилцааг сайжруулахтай холбогдон гарсан бөгөөд төрийн захиргааны байгууллагаас бичгээр зөвшөөрөгдөөгүй хандив болон бусад зардал

¹⁶ гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх.

¹⁷ Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй.

¹⁸ "НББОУС-д заасны дагуу борлуулалт өртгийн аргад хамааралтай хариуцлагын төвөөр нь ангилдаг аргаар удирдлагын зардлыг тусад нь бүртгэнэ.



“Магнай Трейд” ХХК нь 2018 онд “Баянтүмэн-XVII” хайгуулын талбайд “CNPС Greatwall Drilling” ХХК-аар 1 цооногийн өрөмдлөг, деофизикийн судалгааны ажил гүйцэтгүүлэхээр 487,200.0 ам.доллар, мөн “Шинжиан Жэнтун Монголиа Технологи” ХХК-д 1 цооногийн шавар бичиглэл ба цементацийн ажил гүйцэтгүүлэхээр урьдчилгаа төлбөрт 72,000.0 ам.доллар төлж, туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулсан байна.

Гэвч тухайн орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс шалтгаалан дээрх ажлууд хийгдээгүй бөгөөд туслан гүйцэтгэгч компаниудын ажлын урьдчилгаанд төлсөн нийт 559,200.0 ам.долларыг ӨНЗ-д тусгаж тайлагнасныг хасаж тооцон, гэрээт ажлын гүйцэтгэлээр нь баталгаажуулсан болно.



1.2. Гэрээлэгчид БХГ-ээр хүлээсэн зарим чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

“Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн гэрээт Богд-IV болон Онги-V, “Петроматад инвест лимитэд” компанийн гэрээт “Матад-ХХ” хайгуулын талбайн ӨНЗ-д тайлагнасан зарим зардлын нийт 1,296,928 ам.долларын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн байна. Хүснэгт 8-д үзүүлэв.

Хүснэгт 8.

Гэрээлэгч компанийн нэр	Хайгуулын талбай	Оноор /ам.доллар/		Нийт /ам.доллар/
		2017	2018	
“Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд”	Богд-IV	448,935.2	114,559.6	563,494.8
	Онги-V	391,008.2	283,973.6	674,981.8
“Петроматад инвест лимитэд”	Матад-ХХ	54,645.0	3,806.4	58,451.4
Нийт		894,588.4	402,339.6	1,296,928.0

Дээрх үйлдэл нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6¹⁹, “Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.13.9.2²⁰-т заасныг зөрчсөн байж болзошгүй тул Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт шалгуулахаар шилжүүлсэн.

Мөн “Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компани нь Богд-IV болон Онги-V хайгуулын талбайн 2017, 2018 оны ӨНЗ-д тайлагнасан нийт 1,465,167 ам.долларын зардлын холбогдох гэрээг 2009 онд байгуулсан БХГ-ний 3.4.л²¹, Хавсралт Г-ийн 2.1.е.1²²-д заасны дагуу АМГТГ-т хүргүүлээгүй байсан бөгөөд аудитын явцад зөрчлийг арилгасан тул гэрээлэгчид цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч ажиллаа. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 9.

Зардал	Богд-IV /ам.доллар/		Онги-V /ам.доллар/		Нийт /ам.доллар/
	2017	2018	2017	2018	
АМГТГ-т хүргүүлж, хянуулаагүй гаргасан зардлын нийт дүн	331,622.0	270,066.0	464,690.0	398,789.0	1,465,167.0

2017, 2018 онд тус бүр 8 гэрээлэгч Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-д заасны дагуу хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлээгүй бөгөөд дараах шалтгаантай байна. Үүнд:

¹⁹ хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах;

²⁰ 9.Тусгайзөвшөөрөл эзэмшигч хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа:

9.2.хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх ба уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах;

²¹ ...туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмнө гэрээний төслийг Засгийн газрын төлөөлөгчдөд урьдчилан танилцуулж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээ байгуулах бөгөөд гэрээний нэг хувийг Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ.

²² Гэрээлэгч нь гуравдагч этгээдээс зөвлөх, гэрээт үйлчилгээ болон хангамжаар үйлчлүүлэхтэй холбогдсон зардлын зөвшөөрлийг ГТГ-аас урьдчилан бичгээр авна.



Хүснэгт 10.

№	2017 онд			2018 онд		
	Гэрээлэгч компани	БХГ-т талбай	Шалтгаан	Гэрээлэгч компани	БХГ-т талбай	Шалтгаан
1	“Шейман” ХХК	Нялга-XVI	Орон нутгийн эсэргүүцлээс шалтгаалж ажил зогссон	“Гоби энерги партнерс Гмбх” ХХК	Зүүнбаян-XIV	БХГ-г цуцлах шатанд
2	“Гоби энерги партнерс Гмбх” ХХК	Зүүнбаян-XIV	Гэрээг цуцлуулах хүсэлт гаргасан	“Гоби энерги партнерс Гмбх” ХХК	Цагаан-Элс-XIII	БХГ-г цуцлах шатанд
3	“Гоби энерги партнерс Гмбх” ХХК	Цагаан-элс-XIII		“Импайр газ Монголиа” ХХК	Борзон-VII	БХГ-г цуцлах шатанд
4	“Шунхлай энерги” ХХК	Сулин хээр-XXIII	Хайгуулын хугацаа дууссан тул сунгуулах хүсэлт гаргасан	“Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК	Увс-I	Орон нутгийн эсэргүүцлээс шалтгаалж ажил зогссон
5	“Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК	Увс-I	Орон нутгийн эсэргүүцлээс шалтгаалж ажил зогссон	“Ренова Илч” ХХК	Хар ус-II	Шалтгаангүй
6	“Сансрын геологи хайгуул” ХХК	Төхөм-X хойд	Гэрээг цуцлуулах хүсэлт гаргасан	“Сансрын геологи хайгуул” ХХК	Төхөм-X хойд	БХГ-г цуцлах шатанд
7	“Сансрын геологи хайгуул” ХХК	Цайдам-XXVI	Гэрээг цуцлуулах хүсэлт гаргасан	“Сансрын геологи хайгуул” ХХК	Цайдам-XXVI	БХГ-г цуцлах шатанд
8	“Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК	Номгон-IX	Хайгуулын хугацаа дууссан тул сунгуулах хүсэлт гаргасан	“Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК	Номгон-IX	Шалтгаангүй

Эх сурвалж: АМГТГ-ын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 1/4972, 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/441 тоот албан бичиг.

Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан боловч 2017 онд 5, 2018 онд 2 талбайд тус тус хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй, АМГТГ-т -ӨНЗ-ыг тайлагнаагүй байна. Үүнд:

Хүснэгт 11.

2017 онд	2018 онд
“Импайр газ Монголиа” ХХК-ийн Борзон-VII, “Эн Пи Ай” ХХК-ийн Хөх нуур-XVIII, “Хонгконг Вэллэж Индастриал” ХХК-ийн Хэрлэн тохой-XXVIII, “Ренова Илч” ХХК-ийн Хар ус-II, “Монголиа шин ий энерги” ХХК-ийн Дарьганга-XXIV	“Шейман” ХХК-ийн Нялга-XVI, “Шунхлай энерги” ХХК-ийн Сулин хээр-XXIII

Иймд дээрх гэрээлэгчдийн хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан, нөхцөлийг тодруулж, орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс шалтгаалан үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа гэрээлэгчдийн асуудлыг Засгийн газрын зүгээс нэгдсэн арга хэмжээ авч, шийдвэрлэх шаардлага үүсжээ.



БҮЛЭГ 2. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

2.2. АМГТГ нь гэрээлэгчийн ӨНЗ-ын тайланг хяналт тавилгүйгээр хүлээж авсан байна.

Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3²³, 9.1.8²⁴-д заасан АМГТГ-ын чиг үүргийн хүрээнд АМГТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн өртөг нөхөгдөх зардал, газрын тосны бүртгэл тооцоо, хяналт хариуцсан 3 мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн 2017, 2018 оны үр дүнгийн гэрээнд гэрээлэгчийн хөрөнгө оруулалт-зардлын тайланг улирал бүр хянаж хүлээн авах, нэгтгэх ажил тусгагдсан хэдий ч хянаж, хүлээн авах чиг үүрэг бүрэн хэрэгжээгүй байна.

АМГТГ нь гэрээлэгчдийн төсөв, гүйцэтгэл, ӨНЗ-ын тайланг хүлээн авахдаа холбогдох хяналтыг хэрэгжүүлэх болон гэрээлэгчдийн БХГ-ний хэрэгжилтийг хангуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүйгээс гэрээлэгчид энэхүү тайлангийн нэгдүгээр бүлэгт дурдсан зөрчлийг гаргасан байна.

Иймд төрийн захиргааны төв байгууллага буюу УУХҮЯ-нд зөрчлийг давтан гаргуулахгүй байх арга хэмжээ авч, хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Аудитын хамрах хугацаанд хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээлэгчдийн АМГТГ-аар батлуулсан жилийн ажлын төсөв болон гүйцэтгэлийг харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 12.

№	Талбайн нэр	2017 онд /ам.доллар/			2018 онд /ам.доллар/		
		Төсөв	Гүйцэтгэл	Хэрэгжилт /хувиар/	Төсөв	Гүйцэтгэл	Хэрэгжилт /хувиар/
1	Богд-IV	2,577,373.4	2,106,690.9	81.7%	7,461,681.4	7,763,810.3	104.0%
2	Онги-V	6,737,695.4	6,027,551.7	89.5%	8,589,568.8	7,483,084.1	87.1%
3	Матад-XX	363,325.3	536,023.1	147.5%	3,386,901.9	650,435.2	19.2%
4	Төхөм Урд-X	792,174.8	826,880.2	104.4%	4,625,395.6	287,540.5	6.2%
5	Арбулаг-XXIX	2,222,368.6	2,593,620.9	116.7%	3,611,795.5	1,828,403.2	50.6%
6	Эргэл-XII	2,034,205.0	462,893.0	22.8%	-	-	-
7	Сүхбаатар-XXVII	5,794,586.2	275,128.4	4.7%	13,199,660.8	184,931.9	1.4%
8	Баянтүмэн-XVII	-	-	-	4,636,579.6	644,466.6	13.9%
9	Галба-XI	-	-	-	2,655,385.5	198,256.9	7.5%
	Нийт	20,521,728.7	12,828,788.2	62.5%	48,166,969.0	19,040,928.7	39.5%

Хүснэгтэд харуулснаар 2017 онд 7 талбайн нийт батлагдсан төсвийн 62.5 хувь, 2018 онд 8 талбайн нийт батлагдсан төсвийн 39.5 хувьд ногдох зардал хайгуулын ажилд зарцуулагдсанаас үзэхэд төлөвлөсөн хайгуулын ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.

²³ 9.1.3.газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

²⁴ 9.1.8.гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх;



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Зарим гэрээлэгчид Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3²⁵ болон БХГ-нд заасан хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг АМГТГ-аар жил бүр батлуулж, хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй нь орон нутгийн эсэргүүцлээс шалтгаалсан, хайгуулын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан, БХГ-г цуцлах хүсэлт гаргасан зэрэг шалтгаантай, 1 талбайд шалтгаангүйгээр дээрх үүргээ хэрэгжүүлээгүй байна.
2. Аудитад хамрагдсан 7 гэрээлэгч 8 талбайн ӨНЗ-ын тайланд зарим зардлыг Газрын тосны тухай хууль болон БХГ-ний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй тул нийт 1,841,175.9 ам.долларын зардлыг хасаж, ӨНЗ-ын нийт 25,643,657.3 ам.доллараар баталгаажуулав.
3. “Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн гэрээт Богд-IV болон Онги-V, “Петроматад инвест лимитэд” компанийн гэрээт “Матад-ХХ” хайгуулын талбайн ӨНЗ-д тайлагнасан нийт 1,296,928 ам.долларын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн нь Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.13.9.2-т заасныг зөрчсөн байж болзошгүй байна.
4. АМГТГ нь ӨНЗ-ын тайланг хүлээн авахдаа холбогдох хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, Газрын тосны тухай хууль болон БХГ-ээр хүлээсэн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, гэрээлэгчдийн үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй зөрчилтэй ӨНЗ-ын тайланг хүлээн авсан байна.
5. Аудитад хамрагдсан хайгуулын 9 талбайгаас 2017 онд 7 талбайн нийт батлагдсан төсвийн 62.5 хувь, 2018 онд 8 талбайн нийт батлагдсан төсвийн 39.5 хувьд ногдох зардал хайгуулын ажилд зарцуулагдсанаас үзэхэд төлөвлөсөн хайгуулын ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.

²⁵ 11.2.3.жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газар /Ерөнхий сайд У.Хүрэлсүх/-т:

1. Газрын тосны хайгуулын төлөвлөгөө, төсөв батлуулаагүй болон хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх арга хэмжээ авах;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /Д.Сумъяабазар/-д:

1. Гэрээлэгчийн хайгуулын ажлын төсөв, гүйцэтгэлд хяналт тавих, мөн 2017-2018 онд хайгуулын ажил гүйцэтгээгүй гэрээлэгчдийн шалтгаан, нөхцөлийг тодруулах, БХГ-ний хэрэгжилтийг хангуулах чиглэлээр АМГТГ-ын тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авах;
2. Орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс шалтгаалан газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа гэрээлэгчдийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэн холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т:

1. Гэрээлэгчийн хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний зардлын болон ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, зохих арга хэмжээ авч ажиллах;
2. Хайгуулын ажил гүйцэтгээгүй гэрээлэгчдийн шалтгаан, нөхцөлийг тодруулж, нэгдсэн судалгаа гарган, БХГ-ний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах.



Хавсралт 1.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2017 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн төсөв, гүйцэтгэл ӨНЗ, аудитаар баталгаажуулсан дүнгийн нэгтгэл

№	Гэрээлэгч компани	Талбайн нэр	2017 он				
			Төсөв	Гүйцэтгэл	ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Баталгаажсан ӨНЗ
1	"Сентрал азин петролеум"	Богд-IV	2,577,373.4	2,106,690.9	1,663,432.0	310,839.0	1,352,593.0
2	корпорэйшн лимитэд" ХХК	Онги-V	6,737,695.4	6,027,551.7	5,598,329.1	293,064.0	5,305,265.1
3	"Петро матад" ХХК	Матад-XX	363,325.3	536,023.1	321,769.1	30,888.1	290,881.0
4	"Монголын алт" ХХК	Төхөм Урд -X	792,174.8	826,880.2	69,601.3	3,314.3	66,286.9
5	"Макс ойл" ХХК	Арбулаг-XXIX	2,222,368.6	2,593,620.9	1,786,266.5	84,532.7	1,701,733.7
6	"Смарт ойл Монголиа" ХХК	Эргэл-XII	2,034,205.0	462,893.0	78,750.0	3,750.0	75,000.0
7	"Вульф петролеум" ХХК	Сүхбаатар-XXVII	5,794,586.2	275,128.4	70,028.2	3,334.7	66,693.5
8	"Магнай трейд" ХХК	Баянтүмэн-XVII	-	-	-	-	-
9	"Зон Хэн Юу Тиан" ХХК	Галба-XI	-	-	-	-	-
Нийт			20,521,728.7	12,828,788.2	9,588,176.1	729,722.9	8,858,453.2

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн төсөв, гүйцэтгэл ӨНЗ, аудитаар баталгаажуулсан дүнгийн нэгтгэл

№	Гэрээлэгч компани	Талбайн нэр	2018 он				
			Төсөв	Гүйцэтгэл	ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Баталгаажсан ӨНЗ
1	"Сентрал азин петролеум"	Богд-IV	7,461,681.4	7,763,810.3	7,441,791.5	405,375.0	7,036,416.5
2	корпорэйшн лимитэд" ХХК	Онги-V	8,589,568.8	7,483,084.1	7,216,121.7	53,492.0	7,162,629.7
3	"Петро матад" ХХК	Матад-XX	3,386,901.9	650,435.2	300,142.1	872.8	299,269.3
4	"Монголын алт" ХХК	Төхөм Урд-X	4,625,395.6	287,540.5	287,540.5	732.8	286,807.7
5	"Макс ойл" ХХК	Арбулаг-XXIX	3,611,795.5	1,828,403.2	1,828,403.2	87,595.9	1,740,807.3
6	"Смарт ойл Монголиа" ХХК	Эргэл-XII	-	-	-	-	-
7	"Вульф петролеум" ХХК	Сүхбаатар-XXVII	13,199,660.8	184,931.9	77,340.9	3,330.5	74,010.4
8	"Магнай трейд" ХХК	Баянтүмэн-XVII	4,636,579.6	644,466.6	588,137.0	560,054.1	28,082.9
9	"Зон Хэн Юу Тиан" ХХК	Галба-XI	2,655,385.5	198,256.9	157,180.1	-	157,180.1
Нийт			48,166,969.0	19,040,928.7	17,896,657.1	1,111,453.1	16,785,204.0



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70
И-мэйл: info@mram.gov.mn

2020.01.24 № 1/441
танай 2020.01.22-ны № 07/441 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас газрын тосны хайгуулын үйл ажиллагааг 2017-2018 онд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явуулсан гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт - өртөг нөхөгдөх зардалд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж саналаа хүргүүлж байна.

Хавсралт 43 хуудастай

ДАРГА

Х.ХӨРЛЭН

5370487



Ашигт малтмал, газрын тосны газрын
2020 оны 2/4/2020 тоот албан бичгийн
хавсралт

Аудитын тайлангийн төсөл дэх дүгнэлтэд өгөх санал, тайлбар

Санал-1

Дүгнэлтийн 1:

- ❖ 2017 онд 11 гэрээлэгч 12 талбайд хайгуулын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, төсөв батлуулсан. Үүнд:

№	БХГ-т талбай, Гэрээлэгч компани	2017 оны батлагдсан төлөвлөгөөт хайгуулын ажлууд	Төсөв, /ам.доллар/
1	Хар –ус II Ренова илч ХХК	– Геологийн хээрийн судалгаа – 1200 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа	5,289,028
2	Богд IV Капкорп монголиа ХХК	– Геологийн хээрийн судалгаа	1,214,204
3	Онги V Капкорп монголиа ХХК	– Геологийн хээрийн судалгаа – 50 км.кв талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа – Хайгуулын 1 цооног өрөмдөх	8,182,109
4	Борзон VII Импайр газ Монголиа ХХК	– 900 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа – 100 км.кв талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа – Хайгуулын 3 цооног өрөмдөх	18,318,825
5	Эргэл XII Смарт ойл монголиа ХХК	– Геологийн хээрийн судалгаа – Гидрогеологийн судалгаа – 11000 физик цэгт хүндийн хүчний судалгаа /1:100000/	2,034,205
6	Матад XX ПетроМатад ХХК	– Геологийн хээрийн судалгаа – Өмнө хийгдсэн чичирхийлэл, өрөмдлөгийн мэдээллийн дахин боловсруулалт	363,325
7	Дарьганга XXIV Монголиа шин ий энержи ХХК	– 2000 км.кв талбайд сансрын тандан судалгаа – Хайгуулын 1 цооног өрөмдөх	8,980,380
8	Сүхбаатар XXVII Вульф Петролеум ХХК	– 400 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа – Хайгуулын 2 цооног өрөмдөх – 2 цооногт туршилт хийх	5,794,586
9	Арбулаг XXIX Макс ойл ХХК	– 223 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны мэдээллийг дахин боловсруулах – Талбайн хэмжээнд геологийн хээрийн судалгаа – 2454 физик цэгт хүндийн хүчний судалгаа – 2017-2018 оны хайгуулын ажлын нэмэлт төлөвлөгөө, төсвийг 2017.10.16-ны өдөр батлуулсан /Хайгуулын 2 цооног өрөмдөх/	2,222,368 3,611,795
10	Төхөм 10 урд Монголын алт ХХК	– 24706 км.кв талбайд геологийн зураглал, дээжлэлт – 7500 км соронзон хайгуул	792,174
11	Хэрлэнтохой XXVIII Монголиа Вэлпэк индустриал ХХК	– 430 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа	2,271,075
12	Хөхнуур XVIII Эн Пи Ай ХХК	– Гидрогеологийн 1 цооног өрөмдөх – 100 км.кв 3 хэмжээст чичирхийллийн судалгаа – 200 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа – Хайгуулын 3 цооног өрөмдөх	12,304,704



2017 онд 10 талбайн төлөвлөгөө, төсөв батлагдаагүй. Үүнд:

- 4 талбайн (Цагаан-элс XIII, Зүүнбаян XIV, ТөхөмХ хойд, Цайдам XXVI) гэрээг 4 талбай гэрээг цуцлуулах хүсэлт гаргасан.
- 2 талбай (Увс I, Нялга XVI)-д орон нутгийн эсэргүүцлээс үүдэлтэй ажил нь зогссон.
- 1 талбай (Баянтүмэн XVII)-н хайгуулын хугацааг түр зогсоох хүсэлт гаргасан.
- 1 талбай (Галба XI)-н ашиглалтын асуудлыг хэлэлцэж байгаа тул хугацаандаа ирүүлсэн төлөвлөгөө, төсвийг манай талаас батлаагүй.
- 2 талбай (Номгон IX, Сулинхээр XXIII)-н хайгуулын хугацаа дууссан тул сунгуулах хүсэлт гаргасан.

❖ 2018 онд 13 гэрээлэгч 14 талбайд хайгуулын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, төсөв батлуулсан. Үүнд:

ДД	БХГ-т талбайн нэр	Гэрээлэгч компани	2018 оны хайгуулын батлагдсан төлөвлөгөөт ажлууд	Батлагдсан төсөв, сая ам.долл.ар
1	Богд IV	Сентрал Азиан Петролиум Корпорэйшн Лимитад компани	Гадаргуугийн хээрийн дээжлэлт судалгаа, 204 тууш км-т 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, хайгуулын 1 цоонг өрөмдөх, Байгаль орчны ажлууд	7,461,631
2	Онги V		Гадаргуугийн хээрийн дээжлэлт судалгаа, 3 хэмжээст чичирхийллийн боловсруулалт, хайгуулын 1 цоонг өрөмдөх, Байгаль орчны ажлууд	8,589,569
3	Төхөм Х урд	Монголын алт ХХК	1120 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил, 2500 ф.ц-т Хүндийн хүчний судалгааны ажил, Байгаль орчны ажлууд	4,625,395
4	Галба XI	Зон Хэн Юу Тиан ХХК	2 хэмжээст чичирхийллийн хайгуулын материалын дахин боловсруулалт тайлал хийх, Цооногийн туршилт, хэмжилт, тос усыг салгах, Байгаль орчны ажлууд	2,655,386
5	Эргэл XII	Смарт петролеум инвестмент ХХК	550 тууш км-т 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, үр дүнгийн тайлалт боловсруулалт, Байгаль орчны ажлууд	3,008,377
6	Нялга XVI	Шэйман ХХК	2 хэмжээст чичирхийллийн судалгаа	507,038
7	Баянтүмэн XVII	Магнай трейд ХХК	2 хэмжээст чичирхийллийн хайгуулын материалын дахин боловсруулалт тайлал хийх, Хайгуулын 1 цоонг өрөмдөх, цооногийн геофизикийн судалгаа, Цооногийн туршилт, хэмжилт, Байгаль орчны ажлууд	4,636,697
8	Хөх нуур XVIII	Эн Пи Ай ХХК	200 км талбайд 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил болон тайлалт, 100 км2 талбайд 3 хэмжээст судалгааны ажил, хайгуулын 3 цоонг, үүнтэй холбоотой хийгдэх ажил, Байгаль орчны ажлууд	12,325,808
9	Петроматад ХХ	Петроматад ИнвестЛимитад ХХК	Гүехэн цооногийн дээжийн шинжилгээ, 1 хайгуулын цоонг өрөмдөх, Байгаль орчны ажлууд	3,386,302
10	Сулинхээр XXIII	Шунхлай Энержи ХХК	Хүндийн хүчний 1:50000-ны масштабын хайгуул 400 кв.км талбайд	40,200
11	Дарьганга XXIV	Монголиа шиний энержи ХХК	Хайгуулын 2 цоонг өрөмдөх, Каротажийн судалгаа, Шаврын судалгаа, Байгаль орчны ажлууд	4,658,854
12	Сүхбаатар XXVII	Вульф петролеум ХХК	200 км.кв талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгааны хээрийн ажил, боловсруулалт тайлалтын ажил, үр дүнгийн тайлан, хайгуулын өрөмдлөг, Каротажийн судалгаа, Шаврын судалгаа, Цооногийн туршилт, перфораци, Байгаль орчны ажлууд	13,199,661



13	Хэрлэнгохой XXVIII	Монголиа Вэлпэк Индастриал ХХК	430 тууш.км-т хэмжээст чичирхийллийн судалгааны хээрийн ажил, боловсруулалт, Байгаль орчны ажлууд	2,321,076
14	Арбулаг XXIX	Макс ойл XXIX	Хайгуулын 1 цооног	
Н И Й Т				67,416,693.26

2018 онд 8 талбайн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлагдаагүй. Үүнд:

- 5 талбайн БХГ-г цуцлах шатанд (Импайр газ Монголиа ХХК-ийн Борзон VII, DWM Петролеум AG компанийн Цагаан-элс XIII, Зүүнбаян XIV талбайн, Сансарын геологи хайгуул ХХК-ийн Төхөм X хойд, Цайдам XXVI талбай),
- 1 талбай орон нутгийн эсэргүүцэлтэй (Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-ийн Увс I талбай),
- Шалтгаангүйгээр батлуулаагүй 2 талбай (Ренова илч ХХК-ийн Хар-ус II талбай, Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК-ийн Номгон IX талбай).

Санал-2

Дүгнэлтийн 2: Зон хэн юу тиан ХХК-ний 2014 оны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудитын тайланд тус компанийн тухайн жилд ажил нь хийгдэж, зардал нь өртөг нөхөгдөх зардлын тайланд оруулсан 18,022,355.76 ам.долларыг 2016 оны санхүүгийн тайланд тусгасан үед өртөг нөхөгдөх зардалд оруулахаар шийдвэрлэсэн. Дээрх зардлыг "Зон хэн юу тиан" ХХК нь зөвлөмжийн дагуу 2016 оны санхүүгийн тайландаа тусгасан байна. Уг зардлыг хэрхэх талаар аудитын тайланд тусгах,

Санал-3

Дүгнэлтийн 3: Гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлын гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх болон холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаа талаар МХЕГ-тай хамтарч хяналт тавьж, МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагчийн 2019 оны 12 сарын 02-ны өдрийн зөвлөмжийг гэрээлэгч 19 компанид хүргүүлсэн.

Санал-4

Дүгнэлтийн 4.5: Газрын тосны тухай хууль /ГТТХ/-ийн 9 дүгээр зүйлд манай байгууллага буюу төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхой заасан бөгөөд 9 дүгээр зүйлийн 9.1.8-т гэрээлэгчийн тайланг хянаж нэгтгэхээр заасан.

Манай байгууллагын зүгээс өртөг нөхөгдөх зардлын тайлан болон борлуулсан тосны тайланд тавих хяналт нь тухайн ирүүлсэн тайлангийн хувьд тавих тооцооллын хяналт бөгөөд тус тайланд өртөг нөхөгдөх зардлыг үнэн зөв тусгасан эсэхийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтаар хяналт шалгалт хийж, баталгаажуулах хяналтыг ГТТХ-ийн 8 дугаар бүлэг (Мэдээ тайлан, хяналт шалгалт), 37 дугаар зүйлд тодорхой заасан.

Дээрх хуулийн заалтын дагуу Төрийн аудитын байгууллага нь холбогдох байгууллагатай хамтран гэрээлэгчийн төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хяналт шалгалт хийн, баталгаажуулахаар заасан.

Төрийн аудитын байгууллага нь холбогдох байгууллагатай хамтран шалгалт хийнэ гэж заасныг мэргэжлийн байгууллага болох манай байгууллагатай хамтран шалгалт хийнэ гэж ойлгож байсан боловч ҮАГ-ын аудитуудаас АМГТГ нь ҮАГ-аас хийж буй аудит, хяналт шалгалтад хамааралгүй гэж мэдэгдсэн тул манай байгууллагын зүгээс гэрээлэгчдийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад тулгуурлан өртөг нөхөх зардлыг нэг бүрчлэн шалгах эрх зүйн үндэс байхгүй болсон.



АМГТГ нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг хүлээн авч, тайланг тооцооллын хувьд хянаж, нэгтгэх ажлыг холбогдох хууль журмын хүрээнд хэрэгжүүлж ажилладаг.

Аудитын тайлангийн төсөл дэх зөвлөмжид өгөх тайлбар

Зөвлөмж (Монгол Улсын Ерөнхий сайдад):

Санал-5

1. *1.Тус тайланд дурдсан газрын тосны хайгуулын үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, БХГ-ний үүргээ биелүүлдэггүй, хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх арга хэмжээ авах*

2020 оны 1-р сарын 23-ны өдрийн байдлаар газрын тосны хайгуулын шатанд 22 талбайн БХГ хүчин төгөлдөр байгаагаас 6 талбайн БХГ-г цуцлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 3 талбайн БХГ-г цуцлах саналыг УУХҮЯ-нд хүргүүлэх шатанд, 4 талбайн үйл ажиллагаа орон нутгийн эсэргүүцлээс үүдэлтэй зогссон байна.

АМГТГ-аас гэрээлэгч компаниудын БХГ-ний хэрэгжилтийн байдлыг удаа дараа УУХҮЯ-д, улмаар Засгийн газарт танилцуулж, Засгийн газрын 2018.05.02, 2018.10.03, 2019.04.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

Санал-6

Зөвлөмж (Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад сайдад):

1. *"Гэрээлэгчийн хайгуулын ажлын төсөв, гүйцэтгэлд хяналт тавих, 2017, 2018 онд хайгуулын ажил гүйцэтгээгүй гэрээлэгчдийн шалтгаан, нөхцөлийг тодруулах, БХГ-ний хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авах"*

АМГТГ-аас Газрын тосны тухай хуулийн хугацаанд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй гэрээлэгч 2 компанид дараах арга хэмжээ авсан.

- Ренова илч ХХК 2017 онд нийт 16,8 сая ам.долларын хайгуулын ажил хийхээр төлөвлөгөө, төсөв батлуулсан боловч ажлаа хийгээгүй, 2018 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй тул АМГТГ нь хуулийн дагуу хариуцлага тооцуулахаар 2018.08.14-ний өдрийн 1/5564 тоот албан бичгээр МХЕГ-т хандсан. МХЕГ-аас манайд 2018.12.09-ний өдрийн 09/3312 тоот албан бичгээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3-т заасны дагуу хялбаршуулсан журмаар шийтгэлийн арга хэмжээ авч торгууль ногдуулсан боловч гэрээлэгч уг торгуулийг төлөөгүй тул зөрчлийн хэрэг үүсгэсэн. АМГТГ-аас гэрээлэгч компанид БХГ-г хэрэгжүүлэх шаардлага тавьж 2017 оны 1/2490, 3/6779, 1/5758, 2018.01.05-ны өдрийн 1/85, 2018.02.06-ны өдрийн 9/888, 2018.05.02-ны өдрийн 9/3292, 2018.06.06-ны өдрийн 1/4181, 2018.12.25-ны өдрийн 3/8739, 2019.07.02-ны 1/4946 тоот албан бичгүүдийг явуулсан. Гэрээлэгч БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар санаачилга гаргаж ажиллаагүй тул гэрээг цуцлах саналыг УУХҮЯ-нд хүргүүлэхээр гэрээлэгчийн БХГ-ний дагуу төлөх төлбөр болон хайгуулын ажлын доод хэмжээнд зарцуулах зардлыг шүүхээр нэхэмжлэх гэж байна.

- Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК 2014-2016 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан боловч ажлаа хийгээгүй, 2017 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй тул АМГТГ-аас гэрээлэгч компанид БХГ-ний дагуу өмнөх онуудын төлбөрийн үлдэгдлийг төлөх, төлөвлөсөн хайгуул ажлаа хийх үүрэг өгч,



БХГ-гээр хүлээсэн бусад үүргийг биелүүлэх тухай Протоколыг 2018.09.12-ны өдөр байгуулсан. Гэрээлэгч компани уг протоколоор хүлээсэн үүргийг биелүүлээгүй, 2017, 2018 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй тул АМГТГ-аас хуулийн дагуу хариуцлага тооцуулахаар 2017.07.21-ний өдрийн 9/4995, 2017.08.15-ны өдрийн 1/5897, 2018.08.14-ний өдрийн 1/5564 тоот албан бичгээр МХЕГ-т хандсан. АМГТГ-аас 2018.10.22-ны өдрийн 1/7060 тоот албан бичгээр МХЕГ-ын 2018.10.09-ний өдрийн 09/3312 тоот шаардлагын дагуу Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК-д хариуцлага тооцуулахаар зарим нотлох баримтыг нэмж хүргүүлсэн бөгөөд МХЕГ-аас тус компанид зөрчлийн хэрэг үүсгэсэн.

АМГТГ-аас гэрээлэгч компанид БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухай шаардлагыг 2017.03.22-ны өдрийн 1/1886, 2017.08.15-ны өдрийн 1/5897, 2018.02.06-ны өдрийн 9/879, 2018.05.02-ны өдрийн 9/3284, 2018.06.06-ны өдрийн 1/4178, 2018.07.30-ны 9/5250, 2018.12.25-ны өдрийн 3/8716, 2019 оны 01.25-ны 9/512, 2019 оны 02/27-ны 1/1252 тоотуудаар тавьж ирсэн боловч гэрээлэгч компаниас ямар нэгэн арга хэмжээ аваагүй тул гэрээг цуцлах саналыг УУХҮЯ-нд хүргүүлсэн.

Санал-7

2. *Орон нутгийн эсэргүүцлээс шалтгаалан газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа гэрээлэгчдийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэн холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх*

Газрын тосны үйл ажиллагааг ашигт малтмал, уул уурхайн үйл ажиллагаатай адилтган ойлгож, орон нутгаас ихээр эсэргүүцэх болсон. Орон нутгийн эсэргүүцэлтэй холбогдуулан АМГТГ-аас гэрээлэгч компаниудтай хамтран 2017 - 2018 онд Увс аймагт 2 удаа, Баянхонгор аймагт 4 удаа, Өвөрхангай аймагт 5 удаа, Сүхбаатар аймагт 1 удаа, Дорнод аймагт 2 удаа уулзалт зохион байгуулж Газрын тосны хууль эрх зүйн орчин, бүтээгдэхүүн хуваах гэрээ, хайгуулын үйл ажиллагааг сурталчлан танилцуулж, хайгуулын ажил хийх нөхцөл бололцоог бүрдүүлэхээр ажиллаж ирсэн. Тухайлбал,

- Шэйман ХХК БХГ-ний дагуу Нялга XVI талбайд нийт 691.4 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын 2 цооног өрөмдөж 14,8 сая ам.долларыг зарцуулсан. 2013 оноос орон нутгийн эсэргүүцлээс үүдэлтэйгээр үйл ажиллагаагаа зогсоосон тул УУХҮЯ-ны удирдлагын зөвлөлийн 2017.09.20-ны өдрийн 21 тоот шийдвэрээр Нялга XVI талбайн БХГ-ний хайгуулын хугацааг 2013.08.29-2017.07.20-ны өдрийг хүртэл түр зогсооноор тооцсон. Гэрээлэгч компани 2018 онд Нялга XVI талбайд 100 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа хийхээр 507 мянган ам.долларыг төлөвлөсөн боловч хайгуул хийхийг эсэргүүцэж УИХ-ын гишүүн Б.Бат-эрдэнэ 2018.08.16-ны өдрийн 9488 албан тоот "Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд газрын тос олборлох, хайгуулын ажлыг хийхгүй байх, Шэйман ХХК-ийн хайгуулын лицензийг цуцлах асуудлыг шийдвэрлүүлэх тухай", Дэлгэрхаан сумын Хэрлэнтооно багийн ИНХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2018.08.02-ны өдрийн 1 дүгээр, Дэлгэрхаан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018.08.13-ны өдрийн 28 дугаар тогтоолууд "Хайгуулын лицензийг цуцлуулах тухай", Хэрлэнбаян-улаан багийн ИНХ-ын тэргүүлэгчдийн 2018.08.08-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл "Тусгай зөвшөөрлийн хайгуулын лицензийг цуцлуулахаар санал уламжлах тухай", "Хууль тогтоомжид нийцүүлэн Хэрлэнгийн хөдөө аралд хайгуул ашиглалт явагдахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүсэлтийг хууль санаачлах эрх бүхий субъектэд уламжлуулан шийдвэрлүүлэх саналыг Дэлгэрхаан сумын ИТХ, Засаг даргад уламжлах тухай", Хэрлэнбаян-улаан тосгоны ИНХ-ын 2018.08.08-ны өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэл "Хайгуулын үйл ажиллагааг эсэргүүцэх тухай" –ийг тус тус гаргасан. Шэйман ХХК-аас 2018.09.28-ны өдрийн 2018/26 албан тоотой "орон нутгийн асуудлыг шийдэх хүртэл хайгуулын хугацааг түр зогсоох, БХГ-нд ЗГ-ын шийдвэрээр нэг талыг барьсан аливаа нэгэн өөрчлөлт орсон тохиолдолд хуулийн дагуу



нөхөн олговор олгох асуудлыг шийдвэрлүүлэх” хүсэлт гаргасан тул АМГТГ-аас БХГ-ний 23.3-т “орон нутгийн эсэргүүцэл бий болох тохиолдолд талуудын хүсэлтээр хайгуулын хугацааг түр зогсоож болно” гэснийг үндэслэн Газрын тосны тухай хуулийн 9.1.20-д заасны дагуу хайгуулын хугацааг 2018 онд 1 жилээр зогсооноор тооцохоор шийдвэрлэж, гэрээлэгч компанийн саналыг УУХҮЯ, ЗГХЭГ-т танилцуулсан.

- Магнайтрейд ХХК БХГ-ний дагуу Баянтүмэн XVII талбайд нийт 7832 км² талбайд соронзон хайгуул, 3000 физик цэгт хүндийн хүчний, 1073.3 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа хийж 4,2 сая ам.доллар зарцуулсан. 2017 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, хайгуулын хугацааг “түр зогсоох” хүсэлт гаргасан тул УУХҮЯ-нд хүсэлтийг уламжилж уламжилсан, яамнаас ямар нэгэн шийдвэр гараагүй. 2018 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан боловч гэрээт талбайд хамаарах Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018.10.12-ны өдрийн 16 дугаар тогтоол, мөн сумын ИТХ-ын 2018.11.12-ны өдрийн VIII хуралдааны 01 дүгээр тогтоолоор Магнай трейд ХХК-д кемпийн эдэлбэр газрын зөвшөөрөл олгоогүй, өрөмдлөгийн үед орон нутагт ус ашиглах, хог хаягдлын гэрээ байгуулахаас татгалзсан, Босоо хөх Монгол бүлгэм, УИХ-ын гишүүн Х.Болорчулуун, сумын ард иргэдээс өрөмдлөг хийлгэхгүй гэсэн тул гэрээлэгч компани шүүхэд нэхэмжлэл гаргасан.

- КапкорпМонголиа ХХК 2017 онд хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу Онги V талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлыг 10-р сарын 13-ны өдрөөс эхлүүлж 188 км² талбайд буюу төлөвлөсөн ажлын 90 орчим хувийг хийж, Өвөрхангай аймгийн Засаг дарга 12-р сарын 16-ны өдрөөс нутгийн ард иргэдийн эсэргүүцлээс үүдэлтэйгээр, мөн 2018 онд Өвөрхангай аймгийн Гучин-ус сумаас хайгуулын Богд IV талбайд өрөмдлөг хийхийг эсэргүүцэж ажлыг нь зогсоосон. АМГТГ-аас гэрээлэгч компанитай хамтран асуудлыг шийдвэрлэж, гэрээлэгч компани төлөвлөгөөт ажлаа хийж дуусгасан.

БХГ-т талбайд хамаарах нутгийн удирдлагын байгууллага нь Газрын тосны тухай хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлдэг, ард иргэдэд буруу ташаа мэдээлэл өгөх, гэрээлэгчээс хууль бус хөрөнгө оруулалт, хандив, санхүүжилт шаардах, биелүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох байдал гарч байгаа тул АМГТГ-аас УУХҮЯ-тай хамтран орон нутгийн асуудлыг ЗГХЭГ-т танилцуулж, ажлын хэсэг байгуулахаар болсон.

Зөвлөмж (АМГТГ-ын даргад):

Санал-8

1,2-т: Гэрээлэгчийн хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний зардлын болон ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, зохих арга хэмжээ авч ажиллах, Хайгуулын ажил гүйцэтгээгүй гэрээлэгчдийн шалтгаан, нөхцөлийг тодруулж нэгдсэн судалгаа гарган, БХГ-ний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах

Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалт ихээр шаарддаг, эрсдэл өндөртэй, мөн дэлхийн зах зээл дээр түүхий тосны үнэ унасан, эдийн засгийн хямралаас үүдэлтэй хөрөнгө оруулалт татахад хүндрэлтэй байгаа нь гэрээг хэрэгжүүлэх, хайгуулын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгааг харгалзан АМГТГ-аас гэрээний нэг талын хувьд гэрээлэгч компаниудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх чиглэл баримталж ирсэн.

АМГТГ-аас гэрээлэгч компаниудад Газрын тосны тухай хууль, БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулах, ажлаа хийх, төлбөр, урамшууллыг төлөх шаардлагыг удаа дараалан тавьж, 2017 ба 2018 оны эхний улирлын болон хагас жилийн байдлаар БХГ-ний хэрэгжилтийг дүгнэж, байгууллагын цахим



хуудсаар мэдээлсэн. Төлбөр, урамшууллыг төлөөгүй, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй, төлөвлөсөн хайгуулын ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хийж гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг төлөх, гэрээг цуцлах нөхцөл бүрдээд байгаа тухай гэрээлэгч компаниудад тухай бүр мэдэгдэл хүргүүлсэн.

МХЕГ-тай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Газрын тосны тухай хууль болон БХГ-ээр хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа гэрээлэгч компаниудад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх талаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, Зөрчлийн тухай хуулийн 7.13 дахь хэсэг – Газрын тосны тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар танилцуулж, сонсгол хийсэн.

2017 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын ажил хийгээгүй компаниуд:

- Ренова илч ХХК нь манай газарт Африкийн Чад улсад хэрэгжүүлж байгаа газрын тосны хайгуулын төсөлд ихэнх хөрөнгө оруулалтаа зарцуулсан нь Монгол Улс дахь хайгуулын үйл ажиллагаа хэвийн явуулахад доголдол үүсгэсэн тухай тайлбар манай газарт ирүүлсэн. Импайр газ Монголиа ХХК 2017 оны 7-р сарын 29-ний өдөр БХГ-ний хугацаа дууссан.
- Смарт ойл монголиа ХХК 2017 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан боловч УУХҮЯ-аас тусгай зөвшөөрлийг 7-р сард авсан тул ажлаа амжиж хийгээгүй.
- Монголиа шин ий энерги ХХК туслан гүйцэтгэгчдийн визний асуудлаас үүдэлтэйгээр ажил хийгээгүй.
- Эн Пи Ай ХХК, Вульф Петролеум ХХК-иуд санхүүгийн хүндрэл үүссэн тул хайгуулын хугацааг түр зогсоох хүсэлт гаргасан.
- Монголиа Вэлпэк индиастриал ХХК шалтгаангүйгээр ажил хийгээгүй.

2018 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын ажил хийгээгүй компаниуд:

- Монголын алт (МАК) ХХК-иас хөрөнгө оруулалтгүй шалтгаанаар хайгуулын хугацааг түр зогсоосон.
- Смарт ойл Монголиа ХХК, туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсан боловч чичирхийллийн судалгааны хээрийн ажлыг цаг агаарын шалтгаанаар хийгээгүй.
- Шэйман, Петроматад, Магнай трейд ХХК-иуд орон нутгийн эсэргүүцлийн, Шунхлай Энержи, Эн Пи Ай Вульф петролеум ХХК-иуд санхүү, хөрөнгө оруулалтгүй шалтгаанаар ажил хийгээгүй.
- Монголиа шин ий энерги хөрөнгө оруулагч компанийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн шалтгаанаар ажил хийгээгүй.
- Ренова илч, Монголиа Вэлпэк индиастриал ХХК-ууд тодорхой шалтгаангүйгээр ажил хийгээгүй.
- Гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлын гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх болон холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаа талаар МХЕГ-тай хамтарч хяналт тавьж, МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагчийн 2019 оны 12 сарын 02-ны өдрийн зөвлөмжийг гэрээлэгч 19 компанид хүргүүлсэн.



АМГТГ-аас 2017, 2018 онд үйл ажиллагаа явуулаагүй, БХГ-ний хэрэгжилт хангалтгүй Ренова илч ХХК-ийн Хар-ус II талбай, Монголиа шин ий энерги ХХК-ийн Дарьганга XXIV талбайн, Монголиа вэлпэк индустриал ХХК-ийн Хэрлэнтохой XXVIII талбайн гэрээг Газрын тосны тухай хуулийн 12.1.5-д заасныг үндэслэн тус тус цуцлахаар гэрээлэгч компаниудын БХГ-ний дагуу төлөх төлбөр, хайгуулын ажлын доод хэмжээнд зарцуулагдаагүй хөрөнгийг шүүхээр нэхэмжлэх ажлыг зохион байгуулж байна.

Гэрээлэгч компаниудын өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах шалгалтыг 2014 онд газрын тосны тухай хууль шинэчлэгдэн батлагдахаас өмнө бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний холбогдох заалтыг үндэслэн тухайн жилийн ажлын төлөвлөгөөний дагуу Ашигт малтмал, газрын тосны газар мэргэжлийн төрийн байгууллагууд болох Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Татварын Ерөнхий газар зэрэгтэй хамтарч санхүүгийн шалгалтыг 2014 он дуустал хийсэн.

Газрын тосны тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар АМГТГ нь хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д зааснаар гэрээлэгчийн тайланг хянаж нэгтгэх эрх үүрэгтэй болсон. Тус хяналт нь өртөг нөхөгдөх зардлын тайлан болон борлуулсан тосны тухайн ирүүлсэн тайлангийн хувьд тавих тооцооллын хяналт юм.

ГТТХ-ийн 8 дугаар бүлэг, 37 дугаар зүйлд Төрийн аудитын байгууллага нь холбогдох байгууллагатай хамтран гэрээлэгчийн төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хяналт шалгалт хийн, баталгаажуулахаар заасан.

Дээр дурдсан Төрийн аудитын байгууллага нь холбогдох байгууллагатай хамтран хяналт шалгалтыг хийнэ гэж хуульд заасны дагуу 2016 онд ҮАГ болон АМГТГ хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн болон ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Доншен газрын тос (Монгол)" компанийн 2014 оны өртөг нөхөгдөх зардалд санхүүгийн шалгалтыг хамтран хийж гүйцэтгэж байсан.

Гэвч 2018 оноос ҮАГ-ын аудиторуудаас АМГТГ нь ҮАГ-аас хийж буй аудит, хяналт шалгалтад хамааралгүй гэж мэдэгдэж 2014 оноос хойших хугацааны шалгалтад оролцуулаагүй.

Иймээс манай байгууллагын зүгээс гэрээлэгчдийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад тулгуурлан өртөг нөхөх зардлыг нэг бүрчлэн шалгах эрх зүйн үндэс байхгүй болсон.

Харин Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор Газрын тосны бүртгэл тооцооны журам батлагдаж, тус журмын 11 дүгээр зүйлд "Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг анхан шатны баримт материалд үндэслэн хянан шалгаж, дүгнэлт гаргана" гэж заасны дагуу манай байгууллагаас хянаж шалгах эрх зүйн үндэс бий болоод байна.



Үүний дагуу гэрээлэгчдийн 2018 оноос хойших хугацааны , хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг анхан шатны баримт материалд үндэслэн хянан шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг томилж, ажлыг 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байгаа болно.

АМГТГ нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг хүлээн авч, тайланг тооцооллын хувьд хянаж, нэгтгэх ажлыг холбогдох хууль журмын хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байна гэж үзэж байна.



ҮАГ-НАГ/2019/03/-НА
Нийцлийн аудитын тайлан

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах аудит



Wolf Petroleum
Mongolian Oil Exploration Company

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

ВУЛЬФ ПЕТРОЛЕУМ ХХК

1201 тоот, Шангри-Ла оффис, Олимп гудамж
19А, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: +976-77321914

2019.12.20 № 24
танай _____-ны № _____-т

Тайлбар гаргах тухай

Манай компани нь танай байгууллагаас ирүүлсэн Сүхбаатар XXVII талбайн 2017, 2018 оны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулсан аудитын тайлан, дүгнэлттэй танилцлаа.

Уг өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулсан аудитын тайланд өгөх саналгүй болно.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Т. БАТАА



“ЗОН ХЭН ЮУ ТИАН” ХХК

2019 оны 12 сарын 23 ны өдөр

Дугаар №19/

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын дүгнэлтийн талаар

Танай газраас манай компаний 2017-2018 оны өртөг нөхөх зардалд хийсэн аудитын урьдчилсан дүгнэлтийг хүлээн авч танилцлаа.

Уг дүгнэлтэд манай компаний зүгээс татгалзах зүйл болон аливаа санал байхгүй болно.



- 2 *[Signature]*



“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК

Хан-Уул дүүрэг 1-р хороо, 19-р хороолол,
Чингисийн өргөн чөлөө, “Монголын Алт” (МАК)
ХХК-ийн төв байр-44, Улаанбаатар хот 17030, Ш/х-66
Утас: +976-70107482, 75759700; Факс: +976-70107481
Эл.шуудан: mak@mak.mn

2019. 12. 24 № 02/1579

танай _____ - ны (ний) № _____ -т

Санал хүлээн авсан тухай

“Монголын Алт” (МАК) ХХК болон “Ашигт малтмал газрын тосны газар” –ын хооронд байгуулсан “ТӨХӨМ Х УРД” талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх гэрээний 2017, 2018 оны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн мэдээлэлтэй танилцаж, саналыг хүлээн авсныг мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ



Д.САЙНЖАРГАЛ



“Смарт Ойл Монголиа” ХХК
SMART OIL MONGOLIA LLC

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо
Ландмарк Оффисын байр, Баруун жигүүр
Холбоо барих: 77000607

2019.12.26 № 19/26-а

танай _____ ны № _____ -т

“ МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ”

АУДИТЫН ГАЗАР-т

Тайлбар хүргүүлэх тухай

Манай компани нь Монгол Улсын Засгийн Газартай 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр Дорноговь аймгийн Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сумын зарим газар нутгийг хамарсан “ЭРГЭЛ ХП” талбайд газрын тосны хайгуулын ажил гүйцэтгэхээр Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ /БХГ/ байгуулсан билээ. БХГ-ний дагуу гэрээлэгч компани нь ӨНЗТ-г улирал бүр хугацаанд нь гаргаж төрийн захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй байдаг. Үүний дагуу бид 2017 болон 2018 оны холбогдох тайланг гаргаж тайлагнасан. Мөн 2019 онд Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан ГАЗРЫН ТОСНЫ БҮРТГЭЛ, ТООЦООНЫ ЖУРАМ-ын дагуу гаргаж тайлагнаж байна.

Үндэсний Аудитын газраас манай компанийн 2017, 2018 оны тайлангуудад аудитын шалгалт хийгдэж байгаа бөгөөд бидний зүгээс дээрх шалгалтын ажилтай холбогдолтой асууж, тодруулах нэмэлт шаардлагатай материал, мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх зарчмыг баримтлан ажиллаж байна. Танай байгууллагаас Аудитын дүгнэлтийн маягт явуулсаныг хүлээн авч танилцлаа. 2017 оны тайлангын өртөг нөхөгдөх зардлаас хасагдах зардлын дэлгэрэнгүй тайланд Захиргааны зардлын 3750 ам.долларыг ӨНЗ-ын 5%-иар тооцсоныг Захиргааны зардлыг зүйл ангиар тусгайлан тайлагнаагүй, мөн анхан шатны баримтгүйгээр тайланд тусгасан тус хасагдах зардалд оруулсан байна.

Манай компани БХГ-ний хавсралт.Г Бүртгэл тайлан-ийн 2.3.11.2-д захиргааны зардал нь гэрээлэгч компанийн тухайн жилийн өртөг нөхөгдөх зардлын:

Санал-1

а. эхний 10 сая ам.долларт 5 хувь-иар гэсэр заалтын дагуу захиргааны зардлыг тооцох БХГ-ний зарчмын дагуу захиргааны зардлыг шууд тооцон оруулсан. Мөн газрын тосны тухай хуулийн 11.6-д Гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх тухай заасан. Захиргааны зардлыг зүйл ангиар нь тусгайлан тайлагнах тухай заалт БХГ-нд тодорхой ороогүй байна.

Мөн БХГ-ний 2.3.11.5-д Төрийн захиргааны байгууллага нь шаардлагатай үед гэрээлэгчийн захиргааны зардлыг хянана гэж заасан байгаа. 2017 оны бодит гүйцэтгэлээр



удирдлага захирганы зардал 3750 ам.доллараас хэд дахин өндөр гарсан боловч хайгуулын эхний жилийн ӨНЗ бага гарсан тул бид гэрээний зарчмыг баримталж 5 хувиар тооцсон. Мөн 2017 онд манай компани Дорноговь аймагт АМГТГ-тай Орон нутгийн уулзалтыг зохион байгуулсан бөгөөд хуралд оролцсон төлөөлөгчид болон толгой компанийн мэргэжилтнүүд Монгол улсад ажиллах хугацааны зочид буудлын буюу томилолтын зардлууд гарсан.

Манай компани нь “Яшин” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан тус компанийн байранд үйл ажиллагаа явуулдаг байсан ба үйлчилгээний төлбөр төлсний үндсэн дээр оффисын түрээсийн зардал, цалингийн зардал, шатахуун, бичиг хэрэг гэх мэтчилэн захиргааны зардлууд манай компани дээр гараагүй. Яшин ХХК нь манай компанитай холбоотой бүх ажлыг хариуцан гүйцэтгэгдэг байсан. Энэхүү үйлчилгээний төлбөр нь манай компанийн хувьд захиргааны зардалд тооцогдох юм.

Иймд манай компани 2017 оны ӨНЗТ-д тусгасан Захиргааны зардлын 3750 ам.долларыг ӨНЗ-аас хасахыг зөвшөөрөх боломжгүй байна.

Хүндэтгэсэн:

Дэд захирал:



/ ТАНА /



ҮАГ-НАГ/2019/03/-НА
Нийцлийн аудитын тайлан

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах аудит



МАКС ОЙЛ ХХК

Улаанбаатар хот 15170,
Баянгол дүүрэг, 16-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 35,
Ш/Х-433, Утас: 7772323, Факс: 11-312332,
Электрон шуудан: ftn@maxgroup.mn,
Вэб хуудас: www.maxgroup.mn
УБД 9011399103

2019.12.20 № А-24-19/35
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАР-т

Аудитын дүгнэлтийн хариу хүргүүлэх тухай

“Макс ойл” ХХК нь Монгол Улсын Засгийн Газартай байгуулсан Бүтээгдэхүүн Хуваах Гэрээний дагуу Арбулаг-XXIX талбайд газрын тосны хайгуул судалгааны ажлыг хэрэгжүүлж байна.

Манай компаний 2017-2018 онуудын өртөг нөхөх зардлын тайланд Үндэсний аудитын газраас хийсэн хяналт шалгалт, баталгаажуулах дүгнэлтэнд бидний зүгээс ямар нэгэн санал хүсэлт байхгүй болно.

Хүндэтгэсэн:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ - 2



"Петро Матад" ХХК
УБД 9019017097

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2019.01.16 № 001/020
танай -ны -т

Тайлбар хүргүүлэх тухай

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээт Матад ХХ талбайд 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах аудитын ажлын хүрээнд Танай газрын 2019 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр ирүүлсэн Үндэслэлтэй баталгаажуулалтын тайлангийн төсөлд дараах тайлбарыг хавсралтын хамт хүргүүлж байна.

Санал-1

1. Гаднын банкаар хийгдсэн гүйлгээний хувьд, БХГ-т манай толгой компаниас гадаад банкаар дамжуулан хийгдсэн нийт 58.4 мянган ам.долларын гүйлгээнүүд нь хайгуул ба үнэлгээний хөрөнгөөр балансад бүртгэгдсэн бөгөөд БХГ болон Газрын тосны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 178-р тогтоолоор батлагдсан Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 2.1-д заасан ӨНЗ-д тооцогдох үйл ажиллагааны зардал юм. Аудитаар уг зардлыг "хөрөнгө оруулалт" гэж тооцон Зөрчлийн хуулийн 7.13.9.2-т "хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх" ... гэсэн заалтыг зөрчсөн гэж үзсэн нь хууль зүйн үндэслэлгүй байх ба манайд хамааралгүй заалт гэж бид үзэж байна. Хөрөнгө оруулалтын тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль зэргээс харахад "хөрөнгө оруулалт" гэж Монгол улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан биет болон биет бус хөрөнгө байх бол "борлуулалтын орлого" гэж аливаа бараа, ажил үйлчилгээг бусдад төлбөртэйгөөр шилжүүлсний хариуд оруулсан хөрөнгө гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл дээрх Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д заасан хязгаарлалт нь Компанийн хувьд зөвхөн орж ирэх (мөнгөн) урсгалд хамааралтай заалт юм.

"Хайгуул ба үнэлгээний хөрөнгө"/ӨНЗ/ болон "хөрөнгө оруулалт" нь нэр





001/020 албан тоотын 2-р хуудас

томъёоны хувьд хоорондоо ялгаатай ойлголт юм. Хэрэв уг зардлыг урт болон богино хугацаат хөрөнгө оруулалтууд гэж тооцвол уг зардал нь компанийн үндсэн үйл ажиллагаагаар шууд тодорхойлогдохгүй хөрөнгө буюу хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэх зэрэг хөрөнгийн гүйлгээнд тооцогдохоор байна. Гэтэл уг зардлууд нь манай компанийн хайгуулын үндсэн үйл ажиллагаанд шууд хамааралтай, үндсэн үйл ажиллагаагаар тодорхойлогдож буй зардлын гүйлгээнүүд юм. Иймээс манай компани Зөрчлийн тухай хуулийг зөрчөөгүй гэж үзэж байгаа бөгөөд мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэх шаардлагагүй гэж үзэж байна.

Өмнөх жилүүдэд манай толгой компани Петроматад Инвест Лимитедтэй эгч дүүс компани болох газрын тосны хайгуулын Богд IV болон Онги V талбайд БХГ-т Централ Азиан Петролеум Корпорэйшн Лимитедийн гадаад банкаар дамжуулсан гүйлгээнүүдийг үйл ажиллагааны ӨНЗ-аас хасаж тооцсон тухай аудитын дүгнэлтийг шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргасан. Уг гомдол эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа ба анхан шатны шүүхээр уг маргааныг манай талд шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн хувийг хавсаргав. (Хавсралт 1)

Санал-2

2. Батлагдсан хөтөлбөр төсвөөс хэтэрсэн гэж үзэн 2017 оны ӨНЗ-аас нийт 29,412 ам.долларыг хасах нь хууль зүйн үндэслэлгүй байх ба Матад XX талбайн 2017 оны нийт хайгуул, үйл ажиллагааны гүйцэтгэл нь нийт батлагдсан төсвөөс хэтрээгүй тул төсөв хэтрүүлсэн гэж үзэгдэхгүй. Мөн манай Компанийн 2017 оны нийт хайгуул, үйл ажиллагааны нийт гүйцэтгэлд МУ-ын Дээд шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол №443 дагуу шийдвэрлэгдсэн 2010-2012 оны хайгуулын үйл ажиллагааны худалдан авалтын НӨАТ-ын буцаалтын залруулга болох 188,979 ам.долларын багтсан байгаа болно. (Хавсралт 2). Энэхүү залруулгын дүнг оруулахгүйгээр манай Компанийн 2017 оны нийт хайгуул, үйл ажиллагааны гүйцэтгэл нь нийт төсвийн дүнгээс хэмнэлттэй зарцуулалт хийгдсэн байгаа. (Хавсралт 3) Төсвийн хэсэгчилсэн дүнгийн зарим хэсэгт хэмнэлт гаргасан. Зарим хэсгийн дүн инфляц, ам.долларын ханшийн зөрүүнээс үүдэн үл ялиг багахан дүнгээр давсан зарцуулалт байгаа. Өөрөөр хэлбэл, батлагдсан нийт төсвөөс хэтрээгүй байхад хэсгийн дүн хэтэрсэн гэдгээр ӨНЗ-аас хасах хуульчилсан заалт байхгүй. Харин БХГ-ний заалт нь батлагдсан нийт төсөвт





001/020 албан тоотын 3-р хуудас

өртгөөс давсан тохиолдолд нэмэлт тодотгол, нэмэлт өөрчлөлт хийж батлуулах заалт бий.

Мөн тухайн жилийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай бараа, үйлчилгээг олж авахдаа компанийн худалдан авалтын журмын дагуу бараа, үйлчилгээ борлуулагч байгууллагуудыг сонгон шалгаруулж үнэ хөлсөө тохиролцдог. Бүх төрлийн худалдан авалтын мэдээллийг тухай бүр нь АМГТГ-т мэдэгдэж байгаа болно. Өөрөөр хэлбэл, манай компанийн хувьд ӨНЗ-д бүртгэсэн зардлыг улирал бүрийн ӨНЗ-ын тайлангаар дэлгэрэнгүй гүйлгээний жагсаалтын хамт АМГТГ-т цаг хугацаанд нь хүргүүлдэг ба АМГТГ тайлан мэдээг хүлээн авч хянан баталгаажуулдаг. Мөн жил бүрийн хайгуулын ажлын тайланд батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг тусган АМГТГ-т хүргүүлдэг. Хэрэв тухайн жилийн батлагдсан хөтөлбөр төсвийн ажлын цар хүрээнд өөрчлөлт орох тохиолдолд АМГТГ-т мэдэгдэн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт нэмэлт өөрчлөлтийг оруулж, АМГТГ-аар батлуулдаг. Иймд хууль болон БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлж ӨНЗ-ыг тухай бүр АМГТГ-т мэдэгдэн, төсвийн гүйцэтгэл нь батлагдсан хайгуулын ажлын доод хэмжээнээс багагүй ажил хийгдсэн талаар мэдэгдэн баталгаажуулсан байгаа тул энэхүү зардлыг ӨНЗ-д багтана гэж үзэж байна.

- Санал-3** 3. Орон нутгийн олон нийттэй харилцах зардал болох нийт 2,329 ам.доллар нь бодитоор шинэ БХГ зурагдсан 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдрөөс өмнө гарсан байгаа нь холбогдох анхан шатны баримтаар нотлогдож байгаа тул энэхүү зардал нь ӨНЗ-д багтана. Холбогдох анхан шатны баримтуудыг хавсаргав. (Хавсралт 4)

- Санал-4** 4. Нөхөгдөх захиргааны зардлын залруулгыг аудитын эцсийн дүгнэлтээр залруулахыг зөвшөөрч байна.

Хавсралт:

1. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн Шийдвэр №128/ШШ2019/0115
2. МУ-ын Дээд шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол №443
3. Матад ХХ талбайн 2017 оны батлагдсан хөтөлбөр төсвийн гүйцэтгэл
4. Орон нутгийн олон нийттэй харилцах зардал болох нийт 2,329 ам.долларын зардлын анхан шатны баримтууд

=====



001/020 албан тоотын 4-р хуудас

Хавсралт ⁵¹ хуудастай

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал



Жон Хенриксэн





"Капкорп Монголи" ХХК
УБД 9019014069

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2019.01.16 № 001/020
танай _____-ны _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Газрын тосны салбарт Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-т Богд IV болон Онги V талбайд 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардал (ӨНЗ)-ыг хянаж, баталгаажуулах аудитын ажлын хүрээнд Танай газраас 2019 оны 1 дүгээр сарын 07-ны өдөр ирүүлсэн Үндэслэлтэй баталгаажуулалтын тайлангийн төсөлд дараах тайлбарыг хавсралтын хамт хүргүүлж байна.

Санал-1

1. Гадны банкаар хийгдсэн гүйлгээний хувьд, БХГ-т манай толгой компаниас гадаад банкаар дамжуулан хийгдсэн нийт 1.2 сая долларын гүйлгээнүүд нь хайгуул ба үнэлгээний хөрөнгөөр балансад бүртгэгдсэн бөгөөд БХГ болон Газрын тосны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 178-р тогтоолоор батлагдсан Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 2.1-д заасан ӨНЗ-д тооцогдох үйл ажиллагааны зардал юм. Аудитаар уг зардлыг "хөрөнгө оруулалт" гэж тооцон Зөрчлийн хуулийн 7.13.9.2-т "хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх" ... гэсэн заалтыг зөрчсөн гэж үзсэн нь хууль зүйн үндэслэлгүй байх ба манайд хамааралгүй заалт гэж бид үзэж байна. Хөрөнгө оруулалтын тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль зэргээс харахад "хөрөнгө оруулалт" гэж Монгол улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан биет болон биет бус хөрөнгө байх бол "борлуулалтын орлого" гэж аливаа бараа, ажил үйлчилгээг бусдад төлбөртэйгөөр шилжүүлсний хариуд оруулсан хөрөнгө гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл дээрх Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д заасан хязгаарлалт нь Компанийн хувьд зөвхөн орж ирэх (мөнгөн) урсгалд хамааралтай заалт юм.



001/020 албан тоотын 2-р хуудас

"Хайгуул ба үнэлгээний хөрөнгө"/ӨНЗ/ болон "хөрөнгө оруулалт" нь нэр томъёоны хувьд хоорондоо ялгаатай ойлголт юм. Хэрэв уг зардлыг урт болон богино хугацаат хөрөнгө оруулалтууд гэж тооцвол уг зардал нь компанийн үндсэн үйл ажиллагаагаар шууд тодорхойлогдохгүй хөрөнгө буюу хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэх зэрэг хөрөнгийн гүйлгээнд тооцогдохоор байна. Гэтэл уг зардлууд нь манай компанийн хайгуулын үндсэн үйл ажиллагаанд шууд хамааралтай, үндсэн үйл ажиллагаагаар тодорхойлогдож буй зардлын гүйлгээнүүд юм. Иймээс манай компани Зөрчлийн тухай хуулийг зөрчөөгүй гэж үзэж байгаа бөгөөд мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэх шаардлагагүй гэж үзэж байна.

Өмнөх жилүүдэд гадаад банкаар дамжуулсан гүйлгээнүүдийг үйл ажиллагааны ӨНЗ-аас хасаж тооцсон тухай аудитын дүгнэлтийг шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргасан. Уг гомдол эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа ба анхан шатны шүүхээр уг маргааныг манай талд шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн хувийг хавсаргав. (Хавсралт 1)

Санал-2

2. 2018 оны Богд IV талбайн ӨНЗ-аас 151,847 ам.долларын зардал нь 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Синопек Монголиа ХХК-д төлөгдөөгүй байсан тул, танай газрын зөвлөмжийн дагуу уг зардлын төлбөр төлөгдсөн оны хайгуул, үйл ажиллагааны хөтөлбөр төсөвт нэмэлтээр тусган батлуулж ӨНЗ-д шилжүүлэн тооцуулах хүсэлтэй байна. Иймд Танай газрын 2020 хийгдэх УИХ-ын төсвийн байнгын хорооны 2019 оны 5-р тогтоолоор батлагдсан "Газрын тосны салбарт 2019 онд БХГ-ээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөх болон нөхсөн зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалт" аудитаар хянаж баталгаажуулж өгнө үү.

- 2018 оны Богд IV болон Онги V талбайн ӨНЗ-аас Санлотус ХХК-д төлсөн нийт 12,259 ам.долларын зардалтай тэнцэх 32,400,000 төгрөгийн зардал нь 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 21,600,000 төгрөг, 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр 10,800,000 төгрөгийг Санлотус ХХК-д тус тус төлж төлбөрийг барагдуулсан байгаа тул 2018 оны ӨНЗ-аас шилжүүлэх шаардлагагүй гэж үзэж байна. Санлотус ХХК-д төлсөн төлбөрийн баримтуудыг хавсаргав. (Хавсралт 2)

Санал-3

3. Батлагдсан хөтөлбөр төсвөөс хэтэрсэн гэж үзэн ӨНЗ-аас нийт 191,866 ам.доллар



001/020 албан тоотын 3-р хуудас

ба үүнээс Богд IV талбайн 2017 онд 1,112 ам.доллар, 2018 онд 153,845 ам.доллар болон Онги V талбайн 2017 онд 36,909 ам.долларыг хасах нь хууль зүйн үндэслэлгүй байх ба Богд IV болон Онги V талбайн 2017, 2018 он тус бүрийн нийт хайгуул, үйл ажиллагааны гүйцэтгэл нь нийт батлагдсан төсвөөс хэтрээгүй тул төсөв хэтрүүлсэн гэж үзэгдэхгүй. Манай Компанийн 2017, 2018 онуудын нийт хайгуул, үйл ажиллагааны гүйцэтгэл нь нийт төсвийн дүнгээс хэмнэлттэй зарцуулалт хийгдсэн байгаа. (Хавсралт 3, 4, 5, 6-г харна уу) Төсвийн хэсэгчилсэн дүнгийн зарим хэсэгт хэмнэлт гаргасан. Зарим хэсгийн дүн инфляц, ам.долларын ханшийн зөрүүнээс үүдэн үл ялиг багахан дүнгээр давсан зарцуулалт байгаа. Өөрөөр хэлбэл, батлагдсан нийт төсвөөс хэтрээгүй байхад хэсгийн дүн хэтэрсэн гэдгээр ӨНЗ-аас хасах хуульчилсан заалт байхгүй. Харин БХГ-ний заалт нь батлагдсан нийт төсөвт өртгөөс давсан тохиолдолд нэмэлт тодотгол, нэмэлт өөрчлөлт хийж батлуулах заалт бий.

Мөн тухайн жилийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай бараа, үйлчилгээг олж авахдаа компанийн худалдан авалтын журмын дагуу бараа, үйлчилгээ борлуулагч байгууллагуудыг сонгон шалгаруулж үнэ хөлсөө тохиролцдог. Бүх төрлийн худалдан авалтын мэдээллийг тухай бүрт нь АМГТГ-т мэдэгдэж байгаа болно. Өөрөөр хэлбэл, манай компанийн хувьд ӨНЗ-д бүртгэсэн зардлыг улирал бүрийн ӨНЗ-ын тайлангаар дэлгэрэнгүй гүйлгээний жагсаалтын хамт АМГТГ-т цаг хугацаанд нь хүргүүлдэг ба АМГТГ тайлан мэдээг хүлээн авч хянан баталгаажуулдаг. Мөн жил бүрийн хайгуулын ажлын тайланд батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг тусган АМГТГ-т хүргүүлдэг. Хэрэв тухайн жилийн батлагдсан хөтөлбөр төсвийн ажлын цар хүрээнд өөрчлөлт орох тохиолдолд АМГТГ-т мэдэгдэн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт нэмэлт өөрчлөлтийг оруулж, АМГТГ-аар батлуулдаг. Иймд хууль болон БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлж ӨНЗ-ыг тухай бүр АМГТГ-т мэдэгдэн, төсвийн гүйцэтгэл нь батлагдсан хайгуулын ажлын доод хэмжээнээс багагүй ажил хийгдсэн талаар мэдэгдэн баталгаажуулсан байгаа тул энэхүү зардлыг ӨНЗ-д багтана гэж үзэж байна.

Санал-4

4. Компанийн Ерөнхий гүйцэтгэх захирлын цалин болон НДШ зардлын хайгуул, үйл ажиллагаанд хуваарилсан дүнгээс нийт 876,678 ам.доллар (Богд IV талбайн 2017 онд 289,330 ам.доллар, 2018 онд 149,009 ам.доллар болон Онги V талбайн



001/020 албан тоотын 4-р хуудас

2017 онд 289,330 ам.доллар, 2018 онд 149,009 ам.доллар)-ыг ӨНЗ-аас хасаж тооцсон байна. Хэдийгээр гүйцэтгэх захирлын гэрээ байгаа боловч геологи, хайгуулын инженерийн ажил үүргийг давхар хариуцуулна гэж гэрээ байгуулах санал болон ажлын байрны тодорхойлолт, хийгдсэн ажлын тайлан, цагийн хуваарилалт бүртгэлээр нотлогдож байгаа. (Хавсралт 7, 8) Уг баримтууд дээр үндэслэн албан тушаалтнуудын цалин хөлсийг захиргааны болон газрын тосны хайгуулын ажилд оролцсон цагуудыг үндэслэн цалинг ӨНЗ болон захиргааны зардалд тус тус хуваан тооцож олгосон. Өөрөөр хэлбэл, тэдгээрийн бүх цалин хөлсийг шууд ӨНЗ-д тооцоогүй бөгөөд инженерийн хяналтын ажил гүйцэтгэсэн тайлан, цагийн бүртгэлийг үндэслэн цалингийн ажлыг үнэлсэн дүнг ӨНЗ-д оруулсан. Цалингийн бусад хэсгүүд нь захиргааны зардалд хуваарилсан болно. Иймд, ӨНЗ-д тооцсон цалинд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардал ч мөн адил ӨНЗ-д хэсэгчлэн орсон болно. Энэ нь шинэ БХГ-ний Хавсралт Г-ийн 2.3.1.1, 2.3.11.1 заалтуудад нийцэж байгаа юм.

Санал-5 5. Танай Газраас ирүүлсэн Үндэслэлтэй баталгаажуулалтын тайлангийн төсөлд захиргааны зардалд аудит, хуулийн үйлчилгээ болон бусад захиргааны шинжтэй гэж үзэн шилжүүлэхээр тусгасан нийт дүн 77,616 ам.долларын зардлыг дахин нягтлан үзэхэд 64,357 ам.доллар байхаар байна. Иймд 64,357 ам.долларын зардлыг захиргааны зардалд тооцоход татгалзах зүйлгүй.

Санал-6 6. Нөхөгдөх захиргааны зардлын залруулгыг аудитын эцсийн дүгнэлтээр залруулахыг зөвшөөрч байна.

Хавсралт:

1. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн Шийдвэр №128/ШШ2019/0115
2. Санлотус ХХК-д төлсөн төлбөрийн баримтууд
3. Богд IV талбайн 2017 оны батлагдсан хөтөлбөр төсвийн гүйцэтгэл
4. Онги V талбайн 2017 оны батлагдсан хөтөлбөр төсвийн гүйцэтгэл
5. Богд IV талбайн 2018 оны батлагдсан хөтөлбөр төсвийн гүйцэтгэл
6. Онги V талбайн 2018 оны батлагдсан хөтөлбөр төсвийн гүйцэтгэл
7. Ерөнхий гүйцэтгэх захирал Ридван Карпузын гэрээ байгуулах санал, ажлын байрны тодорхойлолт болон цагийн бүртгэлийн хуудас 2017 оны 1 дүгээр сараас 2017 оны 12-р сар хүртэл
8. Ерөнхий гүйцэтгэх захирал Майк Бакын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт болон цагийн бүртгэлийн хуудас 2017 оны 11 дүгээр сараас 2018 оны 12-р сар хүртэл



001/020 албан тоотын 5-р хуудас

Хавсралт ^{7/8} хуудастай

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал



Жон Хенриксэн



АМГТГ-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар-1: Саналыг хүлээн авч, тайланд засвар оруулав.

Тайлбар-2: Аудитын хамрах хугацаанд хамааралгүй тул тайланд тусгах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар-3: Тайлбарын шинжтэй санал байх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар-4: Тайлбарын шинжтэй санал байх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар-5: Тайлбарын шинжтэй санал байх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар-6: Тайлбарын шинжтэй санал байх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар-7: Тайлбарын шинжтэй санал байх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар-8: Тайлбарын шинжтэй санал байх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

“Смарт ойл Монголиа” ХХК-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар-1: Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7-д “Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй” гэж заасан тул саналыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн.

“Петроматад” ХХК-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар-1: Саналыг хүлээн аваагүй бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-т Зөрчлийн тухай хуулийн 7.13.9.2-т заасан зөрчлийг Мэргэжлийн хяналтын улсын байцаагч шалгаж, шийдвэрлэхээр заасан тул дээрх зардлын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн нь хуулийн тухайн заалтыг зөрчсөн байж болзошгүй үндэслэлээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт шалгуулахаар шилжүүлсэн болно.

Тайлбар-2: Саналыг хүлээн аваагүй бөгөөд АМГТГ болон “Петроматад инвест лимитэд” компанийн хооронд 2006 онд байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 5.6²⁶, 2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4.12²⁷-д заасны дагуу өртөг нөхөх зардлаас хасаж тооцсон болно.

Тайлбар-3: Саналыг хүлээн авч, тайланд өөрчлөлт оруулсан болно.

Тайлбар-4: Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн шинжтэй санал байх тул аудитын эцсийн дүнгээр тооцоолсон болно.

“Капкорп Монголиа” ХХК-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар-1: Саналыг хүлээн аваагүй бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-т Зөрчлийн тухай хуулийн 7.13.9.2-т заасан зөрчлийг Мэргэжлийн хяналтын улсын байцаагч шалгаж, шийдвэрлэхээр заасан тул дээрх зардлын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн нь хуулийн тухайн заалтыг зөрчсөн байж болзошгүй үндэслэлээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт шалгуулахаар шилжүүлсэн болно.

²⁶ Өртөгт тос болон хийг тодорхойлох зорилгоор доорх зардлыг нөхөн төлөгдөхгүй зардалд тооцно. Холбогдох ажлын хөтөлбөр, төсөв буюу зарлагын батламжлалын хүрээнд зарцуулагдаагүй зардал.

²⁷ Өртөг нөхөгдөхгүй зардалд дараах зардлыг хамааруулна. Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн.



Тайлбар-2: Саналыг хүлээн авч, тайлант хугацаанд төлөгдсөн дүнгээр өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулсан болно.

Тайлбар-3: Саналыг хүлээн аваагүй бөгөөд АМГТГ болон “Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн хооронд 2009 онд байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 5.6²⁸, 2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний Хавсралт Г-ийн 2.4.2²⁹-д заасны дагуу өртөг нөхөх зардлаас хасаж тооцсон болно.

Тайлбар-4: Саналыг хүлээн аваагүй бөгөөд АМГТГ болон “Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн хооронд 2009 оны БХГ-ний 13.1³⁰, Хавсралт Г-ийн 2.1.л³¹, 2018 онд шинэчлэн байгуулсан БХГ-ний 15.1.1³², Хавсралт Г-ийн 2.3.11.1³³-д зааснаар “захиргааны зардал”-д хамаарах тул бүртгэлийн ангиллыг шилжүүлсэн болно.

Тайлбар-5: Саналыг хүлээн авч, тайланд засвар оруулсан болно.

Тайлбар-6: Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн шинжтэй санал байх тул аудитын эцсийн дүнгээр тооцоолсон болно.

²⁸ Өртөгт тос болон хийг тодорхойлох зорилгоор доорх зардлыг нөхөн төлөгдөхгүй зардалд тооцно. Холбогдох ажлын хөтөлбөр, төсөв буюу зарлагын батламжлалын хүрээнд зарцуулагдаагүй зардал.

²⁹ Өртөг нөхөгдөхгүй зардалд дараах зардлыг хамааруулна. Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн.

³⁰ Гэрээлэгч нь газрын тосны үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хавсралт Г-д заасан журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ...хөтөлнө.

³¹ Захиргааны зардалд Гэрээлэгчийн Монголд буюу гадаад дахь ерөнхий удирдлага болон тэдгээрт туслах ажиллагсад ба тэдгээрийн үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан бодит зардлуудыг бүртгэнэ.

³² гэрээлэгч эсхүл оператор компани нь газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу ...хөтөлнө

³³ Захиргааны зардалд гэрээлэгч эсхүл оператор компанийн Монгол Улсад болон гадаад дахь ерөнхий удирдлага (үүний дотор хувь нийлүүлэгчийн зардал багтана) болон хянах, үйлчлэх, зөвлөх үүрэг бүхий захиргааны ажилтай холбогдон гарах зардлыг бүртгэнэ.



Монгол Улсын Ерөнхий аудитын 2020 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн Хуралгаар тушаалийн Хоёрдугаар хавсгалт

“Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах” сэдэвт нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага

Дэд	Аудитын зорилт чиглэл	Зарчсан хуулийн зүйл заалт	Алдаа зөрчлийн тоол утга	Алдаа, зөрчлөлтэй асуудал гаргасан байгууллага, албан тушаалтны		
				Байгууллага нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5	6
1	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төл болон холбогдох байгууллагад Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.8 хэмээх дүн амжиллагуйгээс 2017-2018 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 7 гэрээлэгчийн 8 талбайн өртөг нөхөх зардалын тайланг нийт 1,841,175.9 ам.долларын зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнахгүй зөрчил гаргасан.	Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.8 хэмээх дүн амжиллагуйгээс 2017-2018 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 7 гэрээлэгчийн 8 талбайн өртөг нөхөх зардалын тайланг нийт 1,841,175.9 ам.долларын зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнахгүй зөрчил гаргасан.	Ашигт малтмал, газрын тосны газарт гэрээлэгчийн өртөг нөхөх зардалын тайланг хууль бусад холбогдох янзалыг бүрэн хэрэгжүүлжгүй. Газрын тосны тухай хууль бусад холбогдох янзалыг бүрэн хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авч амжиллагуйгээс 2017-2018 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 7 гэрээлэгчийн 8 талбайн өртөг нөхөх зардалын тайланг нийт 1,841,175.9 ам.долларын зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнахгүй зөрчил гаргасан.	Ашигт малтмал, газрын тосны газарт	Дарга	Х.Харлан

----- оОо -----